

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө, удирдамжийн дагуу хийсэн нийцлийн аудитын тайлан

“ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН 2016-2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН, ЗАРЦУУЛАЛТ”



АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд мал худалдан авахдаа худалдан авах ажиллагааны журам мөрдөөгүй, санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэд нийгмийн даатгалд бүрэн хамрагдаагүй байгаа зөрчлийг эс тооцвол ХЭДС-гийн хөтөлбөрүүд үр дүнтэй хэрэгжиж байна.

Ааооёяа

Тайланг бэлтгэсэн:

Говь-Алтай аймаг дахь
Төрийн аудитын газар
I баг

Дарга, Тэргүүлэх аудитор
Х.Түвшинбаяр
Утас: 99489309

Аудитын менежер
Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677

Ахлах аудитор
Ж.Бүжинханд
Утас:94008898

Аудитор:
Г.Энхдэлгэр
Утас:99002291

Аудитор:
Б.Шинэбаяр
Утас:99540599

2018 оны 06 дугаар сар

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70483413, 70484055
дугаарын утас, 70484030
дугаарын факсаар
харилцана уу.

Говь-Алтай аймгийн
Есөнбулаг сум
Баянхайрхан баг

Товчилсон үгийн тайлбар
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

Дэд зорилт-1: Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийг төвлөрүүлснээр орлогын эх үүсвэр нэмэгдэж, үйл ажиллагааны үр дүн нэмэгдэх боломжтой байна.

- 1.1 ХЭДС-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө Засаг даргын мөрийн хөтөлбөртэй нийцэж байгаа бөгөөд хөдөлмөр эрхлэлттэй холбоотойгоор үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ 2 жил дараалан 72 хувьтай биелүүлжээ.
- 1.2 Салбар зөвлөлийн гишүүдийг хуульд нийцүүлэн томилж, үйл ажиллагаа, үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай байна.
- 1.3 ХЭДС-ийн хөрөнгийн төлөвлөлтийн үндэслэл болж чадахуйц судалгаа бүхий мэдээллийн сантай байна.
- 1.4 Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулаагүйн төлбөрийг төвлөрүүлээгүй байна.

Дэд зорилт-2: Хөтөлбөрүүдэд шаардлага хангасан иргэдийг хамруулсан бөгөөд ажлын байрыг нэмэгдүүлж, үр өгөөжийг бий болгосон байна.

- 2.1 Ур чадвартай багш бүхий сургалтын төвүүдийг орон нутагтаа бий болгосноор хөдөлмөр эрхлэлтийг дэмжихээр байна.
- 2.2 Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 7 арга хэмжээг хэрэгжүүлсэн бөгөөд санхүүгийн дэмжлэгийг 2016 онд буцалтгүй нөхцөлөөр олгохдоо хамрагдсан иргэдийн 77 хувьд нь дунджаар 746.0 мянган төгрөг хуваарилж, төсөл хэрэгжүүлэх боломжийг нь хязгаарласнаар хөтөлбөрийн үр өгөөжийг бууруулах эрсдэл бий болгожээ.
- 2.3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд дэмжлэгийг хэт багаар олгосон нь ажлын байр бий болгосон хэдий ч үр дүнгээ өгсөн гэж үзэхэд хүндрэлтэй байна.
- 2.4 Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх хөтөлбөр үр дүнтэй хэрэгжсэн байна.
- 2.5 Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр үр дүнтэй хэрэгжиж байна.
- 2.6 Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан 200 малчин өрхөөс 192 өрхийн малын тоо дунджаар 3.9 дахин өсөж үр дүнгээ өгсөн байна.
- 2.7 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Дэд зорилт-3: Дотоод хяналт хийж байгаа гэх боловч нотлох баримт, ажлын тайлан хангалтгүй, сонгон шалгаруулалтын баримт материал байхгүй, гэрээний бүрдэл хэсгүүд дутуу байгаагаас харахад үр дүнгүй ажил болжээ.

- 3.1 Хяналт хийх төлөвлөгөө батлуулж ажилласан хэдий ч цаашид хяналтыг чанартай зохион байгуулж, үр дүнг тайлагнаж байх шаардлагатай байна.
- 3.2 Хяналт шалгалтын байгууллагаас өгсөн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.

Холбогдох байгууллагын санал
Саналын хариу тайлбар
Хавсралтууд

Товчилсон үгийн жагсаалт

МУ	Монгол улс
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХЭХ	Хөдөлмөр эрхлэлтийн хэлтэс
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТББ	Төрийн бус байгууллага
ХЭДХ	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХЭҮЗ	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл
ХЭСЗ	Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, бэрхшээл

Аудит хийх үндэслэл үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн, МУ-ын Ерөнхий аудиторын “Эрх шилжүүлэх тухай” А/188 тушаалаар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд Тэргүүлэх аудиторын баталсан удирдамжийн дагуу “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2016-2017 оны үйл ажиллагааны үр дүн, зарцуулалт”-д нийцлийн аудит хийлээ.

Аудитын зорилт

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2016-2017 оны үйл ажиллагааны үр дүн, зарцуулалтад аудит хийж дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах үндсэн чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- ✚ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлж, үйл ажиллагааг үр дүнтэй төлөвлөж хэрэгжүүлж байгаа эсэх
- ✚ Сангийн хөрөнгийн зарцуулалт, олгосон зээлийн ашиглалт, хөтөлбөрүүд зориулалтын дагуу үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх
- ✚ Сангийн үйл ажиллагаанд тавих хяналт оновчтой, үр дүнтэй байгаа эсэхийг үзлээ.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Говь-Алтай аймгийн ХХҮГ-ын ХЭДС-гийн үйл ажиллагааг хамруулж үзсэн бөгөөд 2016-2018 оны 05 сарын 31-ний өдрийг хүртэлх хугацааны ХЭДС-гийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл хөтөлбөрүүд, эргэн төлөлт, сангийн хэтийн болон үйл ажиллагааны төлөвлөгөө, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, хөгжлийн бодлогын төлөвлөлт, биелэлт, менежерийн бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ, биелэлт, ХЭСЗ-ийн үйл ажиллагаа, батлагдсан төсөв, төсвийн тодотгол, статистик мэдээ, улс орон нутгийн түвшинтэй харьцуулсан судалгаа, санхүүгийн баримт, нягтлан бодох бүртгэл, хурлын тэмдэглэл, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, ХЭДС-гийн үйл ажиллагаанд хийгдсэн дотоод хяналтын ажлын баримт, өгөгдсөн шийдвэр, хэрэгжилтийн тайлан зэргийг хамруулж үзлээ.

Мөн аудитаар ХЭДС-гийн хөтөлбөрийн хэрэгжих хугацаанаас шалтгаалаад 2016 оноос өмнөх оны болон 2018 оны анхан шатны баримт материалыг аудитад хамруулсан болно.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмжийг мөрдөж, нийцлийн аудитын журамд дурдсан арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, төсөвлөлт, зарцуулалтын баримт материалд дахин тооцоолол, тулган баталгаажуулалт, дүн шилжингээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа. Үүнд:

- ✚ ХЭДС-гийн үйл ажиллагааны төлөвлөлт нь аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөртэй нийцэж үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэхийг үзлээ.
- ✚ ХЭСЗ-ийн үйл ажиллагаатай танилцсан. Орон нутгийн орлогод 2016, 2017 онд орсон орлогыг судалж Хөдөлмөр эрхлэлтийн дэд дансны санхүүжилтийн тооцоо хийлээ.
- ✚ Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээний судалгаа, хөдөлмөр эрхлээгүй иргэн, ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэний судалгааг ХХҮГ-аас гаргуулан авч, аймгийн Статистикийн хэлтсийн судалгаагаар харьцуулалт хийлээ.
- ✚ Ажилд зуучлах зартай холбогдуулан гарч байгаа зардлын үр дүнг нэг бүрчлэн тооцож, ажилгүй, ажил олоход хүндрэлтэй иргэдийг ажилд зуучилсан эсэхийг судаллаа.
- ✚ Хөгжлийн бэрхшээлтэй иргэний судалгааг Нийгмийн даатгалын хэлтсийн судалгаанд суурилан, ажил хөдөлмөр эрхлэлтийн байдлыг тодорхойлж, Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй байгууллагын төлбөрийг тооцооллоо.
- ✚ Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр, Ажлын байрыг дэмжих хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр, Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх хөтөлбөр, Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр, Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг анхан шатны баримт болон гэрээнд заасан нөхцөлийг хэрэгжүүлж байгаа эсэхэд бодит байдалд шалган үзлээ.

- ✚ Анхан шатны баримтыг давтан тооцоололт хийж санхүүгийн тайлантай тулгалаа.
- ✚ Дотоодын хяналт тавьсан байдал болон хөндлөнгийн хяналтын шийдвэрийн хэрэгжилтийг үзлээ.

Аудитын стандартын талаарх мэдэгдэл

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, нийцлийн аудитын журмыг ашигласан болно. Аудитад хамрагдсан хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дараах хууль, эрхийн акт, баримт бичгийг аудитын шалгуур болгон ашигласан. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль болон дээрх хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарсан Засгийн газрын тогтоол, бусад холбогдох эрхийн актууд
- Нийцлийн аудитын түр журам, гарын авлага
- Эрх зүйн бусад акт, тогтоол, шийдвэр

Төрийн хяналт шалгалтын стандарт, нийцлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэнд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитын тайлангийн бүтэц түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, холбогдох байгууллагын санал, аудитын шийдвэр болон хавсралт хэсгүүдээс бүрдсэн. Аудитын тайланд аудитын зорилтууд болох дээр дурьдсан 3 асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлс, мэдээллийг хангалттай хэмжээгээр оруулж өглөө. Аудитын тайланг шалгагдагч байгууллагын удирдлага, хамт олон, холбогдох удирдлагуудад танилцуулж, санал авч, аудитын тайланг эцсийн хувилбараар боловсруулан удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилна.

Аудитыг хийсэн багийн бүрэлдэхүүн

Тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр аудитыг удирдан зохион байгуулж, аудитын менежер Д.Эрдэнэчимэг явцын болон чанарын хяналт тавьж стандартыг хангуулан, I багийн ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитор Г.Энхдэлгэр, аудитор Б.Шинэбаяр нар 04 дүгээр сарын 06-ны өдрөөс 06 дугаар сарын 13-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

Аудит хийхэд учирсан бэрхшээл

Аудит хийгдэх хугацаанд дараах бэрхшээл тулгарсан. Үүнд:

- ✚ Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь залуучуудын бизнес санааг дэмжих, тэднийг ажлын байраар хангах зорилгоор “Алтайн баялаг-Залуус” хөтөлбөрийг боловсруулан, үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу “Startupweekend Gowi-altai” хөтөлбөрийг 2018 оны 04 дүгээр сарын 16-ны өдрөөс 20-ны өдрийн хооронд зохион байгуулсан.
- ✚ Аудит хийж байгаа багийн гишүүдийн хүүхдийн эрүүл мэндийн байдлаас шалтгаалан ахлах аудитор 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрөөс 05 дугаар сарын 02-ны өдрийн хооронд, аудитор 2018 оны 05 дугаар сарын 06-ны өдрөөс 13-ны өдрийн хооронд Улаанбаатар хот явсан.
- ✚ ХХҮГ-т Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/105 дугаар тушаалаар яамны дотоод аудит, хяналт шалгалтын газраас тус байгууллагын үйл ажиллагаанд 2018 оны 05 дугаар сарын 07-ны өдрөөс 13-ны өдрийн хооронд хяналт шалгалт хийгдсэн бөгөөд уг хугацаанд аудитад хамрагдсан баримт материалыг буцаан авсан.
- ✚ Үндэсний аудитын газраас Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2018 оны 05 дугаар сарын 13-ны өдрөөс 18-ны өдөр хүртэл чанарын хяналт хийгдсэн.

- ✚ Тус байгууллагын ХЭХ-ийн дарга, мэргэжилтэн нар нь Улаанбаатар хотод Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд 2018 оны 05 дугаар сарын 21-ний өдрөөс 27-ны өдрийн хооронд сургалтад хамрагдсан. Аудит хийгдэх хугацаанд Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яамны дотоод аудит, хяналт шалгалтын газраас ХХҮГ-т шалгалт ирснээр 2017 оны баримт материалыг буцаан авсан боловч уг сургалтанд явахдаа 2017 оны баримт материалыг бидэнд эргүүлэн хүлээлгэн өгөлгүй явснаас хугацаа алдсан зэрэг шалтгааны улмаас нийцлийн аудитыг төлөвлөсөн хугацааг сунгасан болно.

Дэд зорилт-1: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлж, үйл ажиллагааг үр дүнтэй төлөвлөж хэрэгжүүлж байна уу ?

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийг төвлөрүүлснээр орлогын эх үүсвэр нэмэгдэж, үйл ажиллагааны үр дүн нэмэгдэх боломжтой байна.

1.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааны төлөвлөлт нь Засаг даргын мөрийн хөтөлбөртэй нийцэж үр дүнтэй хэрэгжиж байна уу?

ХЭДС-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө Засаг даргын мөрийн хөтөлбөртэй нийцэж байгаа бөгөөд хөдөлмөр эрхлэлттэй холбоотойгоор үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ 2 жил дараалан 72 хувьтай биелүүлжээ.

Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр нь аймгийн ИТХ-ын 2016 оны 12 сарын 5-ны өдрийн 07 дугаар "Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" тогтоолоор батлагдсан бөгөөд хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр 1 дүгээр зүйлийн 1.5-д 5 заалт бүхий дараах хөтөлбөрийг тусгажээ. Үүнд:

- ✚ Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, 20-оос доошгүй байнгын ажлын байрыг бий болгоно.
- ✚ Орон нутгийн баялаг бүтээгчдийн үйл ажиллагааг дэмжих "Бүтээлч-Алтайчууд" хөтөлбөрийг хэрэгжүүлж, 140-өөс доошгүй байнгын ажлын байр бий болгоно.
- ✚ "Ногоон Алтай" хөтөлбөрийн хүрээнд "Ногоон ажлын байр" төслийг хэрэгжүүлж, байнгын 60, түр 100 ажлын байрыг бий болгоно.
- ✚ Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд тулгуурлан мэргэжилтэй ажилтан бэлтгэж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг Политехникийн коллеж болгон өргөжүүлнэ.
- ✚ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлж, ажлын байраар хангаж, амьжиргааг дээшлүүлэх "Бид оролцъё- Хамтдаа хөгжье" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

Эдгээр асуудлын хүрээнд Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн биелэлтийг хавсралтаар харууллаа. /Хавсралт-1/

ХХҮГ-ын дарга нь аймгийн Засаг даргатай 2016, 2017 онд үр дүнгийн гэрээ байгуулахдаа аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан хөдөлмөр эрхлэлттэй холбоотой дээрх 5 асуудлыг бүрэн тусгасан бөгөөд үр дүнгийн гэрээг 2016 онд 83.5 хувь буюу "В", 2017 онд 86.4 хувь буюу "В" дүгнүүлсэн байна.

Үр дүнгийн гэрээнд 2016 онд хөдөлмөр эрхлэлттэй холбоотой нийт 13 ажил үйлчилгээ тусгаж, тодорхой хэмжээнд гүйцэтгэсэн бөгөөд эдгээр 13 ажил үйлчилгээний тухайд 72 хувьтай гүйцэтгэсэн байна.

Мөн 2017 онд 6 чиглэлээр 34 ажил үйлчилгээг тусгаснаас, 32 ажил үйлчилгээг тодорхой хэмжээгээр гүйцэтгэж, 2 ажил үйлчилгээг огт гүйцэтгээгүй байна. Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой 34 ажлыг үнэлбэл 72 хувьтай гүйцэтгэсэн байна. Хэрэгжүүлээгүй 2 ажил үйлчилгээг тодруулбал дараах байдалтай байна. Үүнд:

- ✚ "Ногоон-Алтай" хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар удаан хугацаагаар ажилгүй байсан иргэдийг байнгын болон түр ажлын байраар хангах чиглэлийн хүрээнд хөтөлбөрт хамрагдах иргэдийг “Мод тарих, арчлах” сургалтад хамруулна.
- ✚ “Алтайн-Малчин” хөтөлбөрийн хүрээнд малын гаралтай түүхий эдийг боловсруулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх ур чадварыг хөтөлбөрт хамрагдсан малчин өрхүүдэд эзэмшүүлнэ. /Хавсралт-2/

Дээрх ажлын тухайд эх үүсвэр шийдэгдэж өгөөгүй болон цаг хугацааны хувьд хэрэгжүүлэх боломжгүй шалтгаантай байжээ.

1.2 Салбар зөвлөлийн үйл ажиллагаа нь үр нөлөөтэй байна уу?

Салбар зөвлөлийн гишүүдийг хуульд нийцүүлэн томилж, үйл ажиллагаа, үр нөлөөг дээшлүүлэх хэрэгтэй байна.

ХЭҮЗ хуулийн шинэчилсэн найруулгын дагуу 2012 оны 01 тоот тогтоолоор Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн салбар зөвлөлийн дүрмийг баталсан бол 2017 оны 2 дугаар тогтоолоор Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрмийг шинэчлэн баталсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хуулийн 6.3.1-6.3.4, 6.3.6 заалттай холбоотой батлагдсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлыг аймгийн ХХҮГ болон ХЭСЗ-д даалгаснаар манай аймагт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа явагдаж байна.

ХЭСЗ-ийн дарга нь аймгийн Засаг дарга, гишүүд нь орон нутгийн ажил олгогч, ажилтны байгууллагын төлөөлөл, нарийн бичгийн дарга нь ХЭХ-ийн дарга байхаар дүрмийн дагуу зохицуулсан бөгөөд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7 дахь заалт¹-д ХЭСЗ-д Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын дарга, ажилтныг оруулахыг хориглосон байна. Аймгийн ХЭСЗ-ийн тухайд зөвлөлийн даргаар аймгийн орлогч дарга, нарийн бичгийн даргаар дүрмийн дагуу ХЭХ-ийн дарга байна. Харин 2017 оны 1 дүгээр сард аймгийн Засаг даргын захирамжаар ХЭСЗ-ийг шинэчлэн байгуулахдаа ХХҮГ-ын даргыг зөвлөлийн гишүүнээр томилж, урамшуулал олгосон нь хууль зөрчсөн үйлдэл болжээ.

ХЭСЗ нь аймаг орон нутгийн ИТХ, ЗДТГ болон ХХҮГ-ыг холбосон гүүр бөгөөд хөдөлмөрийн асуудлаар тухайн орон нутагт хийгдэх бодлого, үйл ажиллагаанд нийгмийн зөвшлийн хуралдааны хэлбэрийг ашиглан хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрүүдэд аль сум, дүүргийн хичнээн иргэд, аж ахуйн нэгжийг хамрагдах квотыг тогтоож, зохих зөвлөмжийг өгч ажилладаг нийгмийн зөвшлийн байгууллага байна.

ХЭҮЗ-ийн 2012 оны 1 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийн дагуу 2016 онд улиралд 1-ээс доошгүй удаа хуралдахаар заасан байтал 2016 онд 3 удаа хуралдсан бөгөөд, хурлаар зөвлөлийн ажлын төлөвлөгөө, тухайн онд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрөөс малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдах квот тогтоосон байна. Шинээр 2017 онд батлагдсан “Аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-д зөвлөл нь хагас жилд 1-ээс доошгүй удаа хуралдахаар заажээ. Манай аймгийн ХЭСЗ-ийн тухайд 2017 онд 6 удаа хуралдсан байна.

ХЭҮЗ-ийн 2017 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан “Аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь заалтаар Зөвлөлийн үүргийг тодорхойлсон байна. Үүргийнхээ дагуу дараах ажлыг зохион байгуулжээ. Үүнд:

- ✚ Аймаг орон нутгийн онцлогт тохируулан хөтөлбөр боловсруулан батлуулах ажлын хүрээнд “Ногоон-Алтай”, “Алтайн баялаг- Залуус” нэртэй 398,300.0 мянган төгрөгийн эх үүсвэр шаардах 2 хөтөлбөр боловсруулж ХЭҮЗ болон Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдад хүргүүлсэн байна.
- ✚ Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор “Ногоон Алтай- Ногоон ажлын байр” хөтөлбөрийг 269,300.0 мянган төгрөгөөр, үүнээс 90,000.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, “Бүтээлч Алтайчууд” хөтөлбөрийг 628,200.0 мянган төгрөгөөр, үүнээс 23,000.0

¹ Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний болон аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн гишүүнээр хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын дарга, ажилтныг оруулахыг хориглоно

мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, “Алтай малчин” төслийг 199,600.0 мянган төгрөгөөр, үүнээс 55,000.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр батлуулж хэрэгжүүлэн ажиллаж байна.

- ✚ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд аж ахуй нэгж, төрийн бус байгууллагын санаачилгыг дэмжих, иргэдийн оролцоо, ил тод байдлыг хангах ажлын хүрээнд хамгийн олон ажлын байр бий болгосон аж ахуй нэгж байгууллага шалгаруулж мөнгөн шагналаар шагнаж урамшуулжээ.
- ✚ ХЭҮЗ-ийн ажлын албанаас гаргасан аргачилсан удирдамж, зөвлөмжийг үндэслэн зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарь, томилсон байгууллагадаа ажлаа тайлагнах болон удирдан зохицуулах асуудлыг боловсруулан батлуулж ажилласан байна.
- ✚ Аймгийн ХЭСЗ-ийн 2017 оны үйл ажиллагааны тайланг ХЭҮЗ-д 2018 онд хүргүүлжээ.

Харин баримт материалын хүрээнд дараах чиг үүргүүд орхигдож, хийсэн ажил нь нотлогдохгүй байна. Үүнд:

- ✚ ХЭДС-гийн жижиг зээлийн эргэн төлөлтийн байдалд хяналт тавих
- ✚ Тухайн орон нутагт хэрэгжсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээ, хөтөлбөр төслийн үр дүн нөлөөлөлд жил бүр үнэлгээ хийж, санал дүгнэлт гаргах,
- ✚ Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт болон үр дүнгийн судалгааг тодорхой давтамжтайгаар мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудтай хамтран хийж, хэрэглэгчид, үйлчлүүлэгчдийн зах зээлд эрэлттэй болон илүүдэлтэй мэргэжлийн талаарх мэдээллээр хангах
- ✚ Хөдөлмөр эрхлэлтийн асуудлаар төрийн захиргааны, үйлчилгээний байгууллага, мэргэжлийн боловсрол, сургалт, жижиг дунд үйлдвэр, хөдөө аж ахуй, гэр бүл залуучууд хөгжлийн болон бусад холбогдох асуудал эрхэлсэн байгууллага, бусад хороо зөвлөлүүдтэй үйл ажиллагаагаа уялдуулах
- ✚ Хяналт үнэлгээ хийхдээ ашиглах шалгуур үзүүлэлтийг үйл ажиллагаандаа нийцүүлэн баталж хэрэгжүүлэх.
- ✚ Аймгийн зөвлөлийн 2016 оны үйл ажиллагааны тайланг тухайн үед хариуцаж байсан мэргэжилтэн Н.Баярсайхан нь ХЭҮЗ-д хүргүүлээгүй байна.

Зөвлөлийн дүрэмд тусгагдсан чиг үүргүүдийг орхигдуулж байгаа нь зөвлөлийн үйл ажиллагааны үр нөлөөг бууруулж байна.

ХЭҮЗ-ийн 2017 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан “Аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийн 3 дугаар зүйлийн 3.7 дахь заалт²-д зөвлөлийн гишүүдэд урамшуулал олгохоор байна. Урамшууллын хэмжээг 2017 онд Нийгмийн хамгааллын сайдын А/75 тоот тушаалаар шинэчлэн баталсан бөгөөд аймаг, нийслэл, сум дүүргийн зөвлөлийн гишүүдэд ажлын оролцоо, хурлын ирцийг харгалзан улирал тутам 150.0 мянган төгрөг олгохоор тогтоосон. Гэтэл Зөвлөлийн гишүүдэд урамшуулал олгохдоо ажлын оролцоог үнэлэлгүйгээр зөвхөн хурлын ирцийг харгалзан 2016 онд 7 гишүүнд 1,680.0 мянган төгрөгийн урамшуулал олгож, ажил олгогчоос 184.8 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байна. 2017 онд 9 хүнд 3,375.0 мянган төгрөгийн урамшуулал олгож, ажил олгогчоос 371.3 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл төлж, 53.7 мянган төгрөгийн үйл ажиллагааны зардал гаргаснаар 3,800.0 мянган төгрөг зарцуулсан байна. /Хавсралт-3/

Дүрэмд зааснаар ХЭСЗ-ийн дарга нь аймгийн Засаг дарга байхад Засаг даргын орлогч зөвлөлийн даргаар, зөвлөлийн гишүүнээр ХХҮГ-ын дарга ажиллаж байна. Иймд зөвлөлийн бүрэлдэхүүнийг хуулийн дагуу шинэчлэн тогтоож, дүрмийн дагуу үйл ажиллагааг эрчимжүүлэн, үр нөлөөг дээшлүүлж, урамшуулал олгохдоо зөвхөн хурлын ирцийг харгалзах бус ажлын оролцоог дүгнэж олгох хэрэгтэй байна.

² Зөвлөлийн гишүүдэд хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хэмжээгээр гишүүний оролцоог харгалзан зөвлөлийн нарийн бичгийн даргыг хамруулан урамшуулал олгоно. Урамшуулал болон зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын төсөвт тусган Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлнэ.

1.3 Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээний судалгаа, хөдөлмөр эрхлээгүй иргэн, ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэний судалгааг тогтмол хийж төлөвлөлтийн үндэслэл болгож чадаж байна уу?

ХЭДС-ийн хөрөнгийн төлөвлөлтийн үндэслэл болж чадахуйц судалгаа бүхий мэдээллийн сантай байна.

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд ажил олоход хүндрэлтэй болон ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэдийн бүртгэл, хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээний судалгаа гаргах, мэдээ

ажил олгогчоос гаргуулан авах, ажил хайгчийг тохирох ажлын байранд зуучлах, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх зэрэг арга хэмжээг зохион байгуулах, хяналт тавих эрх бүхий байгууллага юм.

ХХҮГ нь хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн систем болох LMIS программд аймгийн хэмжээний нийт ажил олгогчдын ажиллах хүч, ажлын байрны мэдээллийг шивж оруулсан байна. Мэдээллийг дараах хүснэгт, графикаар харуулъя.

Хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдал

Хүснэгт-1

№	Үзүүлэлт	Огноо	
		2016 он	2017 он
1	Хөдөлмөрийн насны хүн ам	33560	35864
4	Ажиллагсад	23807	23903
5	Ажилгүй иргэд	2245	2717
6	Бүртгэлтэй ажилгүй иргэн	786	796
7	Шинээр бий болсон ажлын байр	396	1275
8	Ажлын байранд зуучилсан иргэн	576	915
9	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	72.5	66.6
10	Ажиллах хүчний оролцооны түвшин	77.6	74.7
11	Ажилгүйдлийн түвшин	10.1	8.6

График-1



Дээрх судалгаанаас үзэхэд тус байгууллага нь аймгийн хэмжээнд 2016 онд 786 ажилгүй иргэнийг бүртгэн, 396 ажлын байрны захиалга авч, 576 иргэнийг ажилд зуучилсан бол 2017 онд 796 ажилгүй иргэнийг бүртгэн, 1275 ажлын байрны захиалга авч, байнгын болон түр, улирлын ажлын байранд 915 иргэнийг ажилд зуучилсан тайлан гаргасан байна. 2016-2017 онуудад ХХҮГ-аар дамжин ажилд орсон иргэдийн тоон үзүүлэлтүүдийг дараах төрлөөр харууллаа.

Ажлын байрны төрөл

Ажилд орсон иргэдийн тоо

	2016 он	2017 он
Байнгын ажлын байр	214	576
Түр ажлын байр	349	310
Улирлын ажлын байр	15	29
Ажлын байранд зуучилсан иргэний тоо	576	915

Хөдөлмөр эрхлэлтийн судалгаанаас харахад шилжилт хөдөлгөөн багассантай холбогдуулан 2016-2017 онд ажилгүй иргэдийн тоо өссөн байгаа ч ажлын байрны тоо нэмэгдсэн байгааг дээрх статистик тоон үзүүлэлт харуулж байна.

Үндэсний статистикийн хорооны цахим хуудсан дахь судалгаанд үндэслэн Говь-Алтай аймгийн ажилгүйдлийн түвшнийг улсын болон бусад аймгуудын дундажтай харьцуулсан судалгааг дараах байдлаар харууллаа.

График-2



График-3



Эдгээр судалгаанаас харахад Говь-Алтай аймгийн ажилгүйдлийн түвшин 2016 онд 10.1 хувьтай байхад 2017 онд 8.6 хувь болон буурсан сайн үзүүлэлттэй байгаа бөгөөд улсын хэмжээнд 11 дүгээрт жагсаж, улсын дундаж түвшинтэй ойролцоо байна.

ХХҮГ нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 9 дэх заалтад заасны дагуу чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллан, хөдөлмөрийн зах зээлийн талаарх мэдээлэл, хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаа, арга хэмжээнд хамрагдах иргэн, үйлчилгээ үзүүлэгч, ажил олгогчийн талаар мэдээллийн санг бүрдүүлж, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг шат шатандаа тооцож ажиллаж байна.

1.4 Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийг бүрдүүлэх орлогын эх үүсвэрийн хэрэгжилт үр дүнтэй байна уу?

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулаагүйн төлбөрийг төвлөрүүлээгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 26 дугаар тогтоолоор аж ахуйн нэгж, байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй орон тоо тутамд сар бүр төлөх төлбөрийн хэмжээг баталсан байна.

Аж ахуйн нэгж, байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй орон тоо тутамд сар бүр төлөх төлбөрийн хэмжээ /Хүснэгт-2/

Дд	Аж ахуйн нэгж, байгууллагын ажилчдын тоо (бүсээр)	50 хүртэл ажиллагчтай	51-с дээш ажиллагчтай
1	Улаанбаатар хот, Орхон, Дархан-Уул аймаг	Хөдөлмөр хөлсний доод хэмжээний 40 хувиар	Хөдөлмөр хөлсний доод хэмжээний 50 хувиар
2	Бусад аймаг	Хөдөлмөр хөлсний доод хэмжээний 30 хувиар	

ХЭДС-гийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийг 2016, 2017 онд огт төвлөрүүлээгүй байна. Аудитаар 25 ба түүнээс дээш ажиллагсадтай аж ахуйн нэгж, байгууллагын судалгааг үзэх гэсэн боловч аудитын хугацаанд судалгаа ирүүлээгүй бөгөөд аудитын тайлангийн төсөл хүргүүлсний дараа 2017 оны 3 сарын 30-ны өдрөөр гаргасан судалгаа ирүүлсэн. Уг судалгааг шинэчилж гаргаагүй, он хуучирсан, ор нэр төдий гаргасан ба аудитаар хийсэн судалгаанаас ихээхэн хэмжээгээр зөрүүтэй байна. Иимд цаашид судалгааг байнга баяжуулан, сайжруулж, ашиглах шаардлагатай байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.1-д / 25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулна/, 111.2-т /Аж ахуйн нэгж байгууллага энэ хуулийн 111.1-д заасан хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд сар бүр төлбөр төлнө/ гэж заасны дагуу аймгийн хэмжээний хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүний нэгдсэн Нийгмийн даатгалын хэлтсээс авч, 25 ба түүнээс дээш ажилтантай байгууллагын ажил эрхлэлтийн байдлын судалгаа хийлээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн судалгаа /мянган төгрөг/

Хүснэгт-3

ДД	Огноо	25 ба түүнээс дээш ажилтантай байгууллагын тоо	Ажиллуулбал зохих ХБИ-ий тоо	Ажиллуулсан ХБИ-ий тоо	Ажиллуулаагүй ХБИ-ий тоо	ХБИ ажиллуулаагүйн төлбөр
1	2016 он	74	157	172	33	21,600.0
2	2017 он	74	159	193	26	18,396.0
3	2018 оны 05 сар дуустал	74	170	168	29	9,720.0
	ДҮН					49,716.0

Аж ахуйн нэгж, байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхлэх боломжтой ажил, мэргэжлийн жагсаалтыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн баталсны дагуу Цагдаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хэлтэс, Хилийн цэргийн анги, Онцгой байдлын хэлтсийн хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулбал зохих төлбөрийг чөлөөллөө.

Ажилчдын тоо 25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагуудыг түүвэрлэн үзэхэд 2016 онд 21,600.0 мянган төгрөгийн, 2017 онд 18,396.0 мянган төгрөгийн, 2018 оны 05 сарыг дуустал хугацаанд 9,720.0 мянган төгрөгийн нийт 49,716.0 мянган төгрөгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажиллуулаагүйн төлбөр төлүүлэхээр судалгаа гарч байна. /Хавсралт 4а, 4б/

Дэд зорилт-2: Сангийн хөрөнгийн зарцуулалт, олгосон зээлийн ашиглалт, хөтөлбөрүүд зориулалтын дагуу үр дүнтэй хэрэгжиж байна уу ?

Хөтөлбөрүүдэд шаардлага хангасан иргэдийг хамруулсан бөгөөд ажлын байрыг нэмэгдүүлж, үр өгөөжийг бий болгосон байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, санхүүжилт

ХЭҮЗ-ийн 2015 оны 09 дүгээр тогтоол, 2017 оны 01 дүгээр тогтоолоор 2016, 2017 онд хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжихтэй холбогдуулан дараах хөтөлбөрүүдийг баталж хэрэгжүүлжээ. Үүнд:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр

Хүснэгт-4

ДД	2016 онд хэрэгжүүлсэн хөтөлбөр	ДД	2017 онд хэрэгжүүлсэн хөтөлбөр
1	Аж ахуй эрхлэх бичил бизнесийг дэмжих хөтөлбөр	1	Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох хөтөлбөр
2	Хөдөлмөрт эрхлэлтийн үр чадвар олгох, ажлын байрыг дэмжих хөтөлбөр	2	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр

3	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	3	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр
4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр
5	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	5	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
6	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний төсөл	6	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх хөтөлбөр
7	Нийтийг хамарсан ажил зохион байгуулах хөтөлбөр		
8	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээг дэмжих хөтөлбөр		

МУ-ын ЗГ-ын 2011 оны 375 дугаар тогтоолоор” Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгох журам”-ыг тус тус баталжээ. ХЭДС-гийн хөрөнгийг ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, ажилд зуучлах, мэргэжлийн сургалтад хамруулах, нийтийг хамарсан ажил зохион байгуулах, ажил олгогчийг дэмжих, хувиараа болон өрхийн, эсхүл нөхөрлөл, хоршооны хэлбэрээр аж ахуй эрхлэх иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн зах зээлийг мэдээллээр хангах, мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих шинэ үйлчилгээ, арга хэмжээг турших, нэвтрүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт тохирсон хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд зориулдаг байна.

Нийцлийн аудит хэдийгээр 2016-2017 оныг хамарч байгаа боловч Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2014, 2015 онд, Хувиараа хөдөлмөр эрхлэгч нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2015 онд эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжилт олгон гэрээ байгуулснаар төлөлт нь 2016-2018 онд хамрагдаж байгаа тул эдгээр хөтөлбөрүүдийн 2014, 2015 оны баримт материал, гэрээний дагуу зээлийн эргэн төлөлтийг үзэх зайлшгүй шаардлага гарсан. Иймд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд зарцуулсан хөрөнгийн судалгааг 2014 оноос 2017 оныг дуустал нэгтгэж дараах хүснэгтээр харууллаа.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт зарцуулсан хөрөнгийн судалгаа
Хүснэгт-5 /мянган төгрөг/

Хөтөлбөрийн нэр	2014 он		2015 онд		2016 онд		2017 он		Нийт дүн	
	хүн тоо	зарцуулсан	хүн тоо	зарцуулсан	хүн тоо	зарцуулсан	хүн тоо	зарцуулсан	хүн тоо	зарцуулсан
1 Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ	-	-	-	-	1,200	10,310.00	912	4,377.00	2,112	14,687.00
2 Ажилд зуучлах үйлчилгээ	-	-	-	-	7	2,488.00	16	1,996.50	23	4,484.50
3 Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр	-	-	102	135,000.00	98	147,091.40	-	-	200	282,091.40
4 Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байр хадгалах хөтөлбөр	-	-	-	-	120	42,721.30	65	16,625.00	185	59,346.30
5 Ажлын байрыг дэмжих хөтөлбөр					385	45,286	643	306,302.20	1,028	351,588.60
6 Залуучууд, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийн ХЭД хөтөлбөр	-	-	-	-	10	20,240.00	16	32,911.20	26	53,151.20
7 Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ХЭД хөтөлбөр	-	-	-	-	45	40,890.00	20	37,672.00	65	78,562.00
8 Малчдын ХЭД хөтөлбөр	40	160,000.00	60	264,100.00	60	269,800.00	40	185,000.00	200	878,900.00
9 Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр					38	7,620.00	45	21,500.00	83	29,120.00
Хөтөлбөрт зарцуулсан зардлын дүн	40	160,000.00	162	399,100.00	1,925	586,447.20	1,751	606,383.90	3,878	1,751,931.10

Дээрх судалгаанаас үзэхэд 2014-2017 онд хэрэгжсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 9 хөтөлбөрт 3,878 иргэдийг хамруулан 1,751,931.1 мянган төгрөгийн санхүүжилтийг олгожээ. /Хавсралт-5а, 5б/

Аудитаар ХЭДС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн хөтөлбөр тус бүрээр олгож байгаа санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийг хөтөлбөрт хамрагдсан иргэн бүрээр гарган тооцоо нийлсэн. /Хавсралт-6, 7, 8, 9, 10, 11, 12/

Эргэн төлөгдөх нөхцөлтэй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн судалгааг нэгтгэн дараах хүснэгтээр харууллаа.

Эргэн төлөгдөх нөхцөлтэй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн судалгаа
Хүснэгт-6 /мянган төгрөг/

ДД	Хэрэгжүүлсэн хөтөлбөр	Хөтөлбөрийн нөхцөл				Эргэн төлөлт				Нийт төлөлт	Авлагын үлдэгдэл	Гэрээт хугацаанд төлөөгүй үлдэгдэл
		Буцаан төлөгдөх нөхцөл	Хамрагдсан огноо	Хугацаа/ жил	төлөгдөх дүн	2015 он	2016 он	2017 он	2018 оны 05 сар			
1	Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл хоршоо байгуулах иргэнийг дэмжих	50 хувь	2015 он	2	67,500.0	4,918.0	40,613.4	15,517.9	4,077.8	65,127.1	2,372.9	2,372.9
2	Ажлын байрыг дэмжих	100 хувь	2017 он	2	87,000.0			15,580.0	20,244.7	35,824.7	51,175.3	4,183.9
3	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	100 хувь	2017 он	2	30,000.0			3,849.8	7,408.5	11,258.3	18,741.7	1,852.0
4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих	100 хувь	2017 он	2	30,000.0			3,287.0	6,995.5	10,282.5	19,717.5	2,557.0
5	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	50 хувь	2014 он	3	100,000.0		24,950.0	50,320.0	15,850.0	91,120.0	8,880.0	8,880.0
		50 хувь	2015 он	2	132,050.0		2,000.0	105,610.0	16,280.0	123,890.0	8,160.0	8,160.0
		50 хувь	2016 он	2	134,900.0			5,250.0	88,225.0	93,475.0	41,425.0	12,984.5
		100 хувь	2017 он	2	185,000.0				26,850.0	26,850.0	158,150.0	0.0
6	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний төсөл	100 хувь	2017 он	2	7,500.0			1,203.5	2,819.2	4,022.7	3,477.3	33.8
Нийт дүн					773,950.0	4,918.0	67,563.4	200,618.2	188,750.7	461,850.3	312,099.7	41,024.1

Хөдөлмөр эрхлэлтийн дээрх 6 хөтөлбөрийн хүрээнд эргэн төлөгдөх нөхцөлтэй 773,950.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосноос 2018 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 312,099.7 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, 41,024.1 мянган төгрөгийг гэрээт хугацаанд төлүүлээгүй байна.

ХЭДС-ийн 2017 оны санхүүгийн тайлангийн баталгаажуулах аудитаар санхүүгийн дэмжлэгийн гэрээт хугацаанд төлөгдөөгүй үлдэгдэлд 12,139.3 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон бөгөөд аудитын шийдвэрийг давхардуулан гаргахгүйн үүднээс шийдвэрийн хэрэгжилтийг хөтөлбөр бүрээр тооцож дараах хүснэгтээр харууллаа.

Санхүүгийн дэмжлэгийн гэрээт хугацаанд төлөгдөөгүй үлдэгдлийн судалгаа

Хүснэгт-7

/мянган төгрөг/

ДД	Хэрэгжүүлсэн хөтөлбөр	Хөтөлбөрийн нөхцөл				Авлагын үлдэгдэл	Гэрээт хугацаанд төлөөгүй үлдэгдэл	2017 оны СТА-ын шийдвэрийн хэрэгжилт			Аудитаар шийдвэр гаргах дүн	Үүнээс гэрээний	
		Буцаан төлөгдөх нөхцөл	Хамрагдсан огноо	Хугацаа/ жил	төлөгдөх дүн			тогтоосон акт	төлөгдсөн	төлөгдөөгүй үлдэгдэл		хугацаа дууссан	хугацаа дуусаагүй
1	Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл хоршоо байгуулах иргэнийг дэмжих	50 хувь	2015 он	2	67,500.0	2,372.9	2,372.9	0.0		0.0	2,372.9	2,372.9	
2	Ажлын байрыг дэмжих	100 хувь	2017 он	2	87,000.0	51,175.3	4,183.9	5,226.2	4,093.7	1,132.5	3,051.4		3,051.4
3	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	100 хувь	2017 он	2	30,000.0	18,741.7	1,852.0	2,646.2	2,296.2	350.0	1,502.0		1,502.0
4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих	100 хувь	2017 он	2	30,000.0	19,717.5	2,557.0	3,651.5	2,729.5	922.0	1,635.0		1,635.0
5	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	50 хувь	2014 он	3	100,000.0	8,880.0	8,880.0				8,880.0	8,880.0	
		50 хувь	2015 он	2	132,050.0	8,160.0	8,160.0				8,160.0	8,160.0	
		50 хувь	2016 он	2	134,900.0	41,425.0	12,984.5				12,984.5	12,984.5	
		100 хувь	2017 он	2	185,000.0	158,150.0	0.0				0.0	0.0	0.0
6	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний төсөл	100 хувь	2017 он	2	7,500.0	3,477.3	33.8	615.4	615.4	0.0	33.8		33.8
Нийт дүн					773,950.0	312,099.7	41,024.1	12,139.3	9,734.8	2,404.5	38,619.6	19,412.9	19,206.7

Дээрх судалгаанаас үзэхэд санхүүгийн тайлангийн аудитаар тогтоогдсон төлбөрийн актнаас 2,404.5 мянган төгрөгийг төлүүлээгүй байна.

Хөтөлбөрүүдэд хамрагдсан огноо, хугацааг харахад Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр, Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн 2014, 2015 онуудад олгосон дэмжлэгийн гэрээний хугацаа бүрэн дууссан байхад нийт 19,412.9 мянган төгрөгийн зээлийг буцаан төлөөгүй байна.

Мөн гэрээний хугацаа дуусаагүй боловч гэрээнд заасан эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлбөл зохих дүнг тооцож үзвэл Ажлын байрыг дэмжих, Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих, Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг дэмжих хөтөлбөрийн хүрээнд нийт 19,206.7 мянган төгрөгийг төлүүлээгүй байна.



Гэрээний хэрэгжилт

ХХҮЕГ-ын даргын тушаалаар батлагдсан хөтөлбөрүүдийн гэрээний загварын 3 дугаар зүйлд нийгмийн даатгалын сайн дурын эсвэл заавал даатгалд хамрагдсан байхаар зааж өгсөн. Аудитаар дэмжлэгт хамрагдсан иргэдийг нийгмийн даатгалд даатгуулж байгаа эсэхийг Нийгмийн даатгалын программтай тулгалт хийн баталгаажуулахад Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2016 онд 44, 2017 онд 20, нийт 64 иргэн санхүүгийн дэмжлэг авсан боловч гэрээнд заасны дагуу нийгмийн даатгалд хамруулаагүй, ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2016 онд 96, 2017 онд 39, нийт 135 иргэн санхүүгийн дэмжлэгт хамрагдаж, үүнээс 20 иргэн нийгмийн даатгалд даатгуулсан байна. Мөн ХЭҮЗ-ийн "Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгч, төгсөгчийн бүлэгт эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэг олгох гэрээ"-г байгуулахдаа гэрээний батлагдсан загварын 3 дугаар зүйлийн 3.9 дэх заалт /Нийгмийн даатгалын сайн дурын эсвэл заавал даатгалд хамрагдсан байна/-ыг орхигдуулсан бөгөөд төсөлд хамрагдсан 13 иргэний 11 иргэн нийгмийн даатгалд огт хамрагдаагүй байна. Энэ нь нэг талаараа бодит ажлын байр бий болгосон гэж үзэх боломжгүй нөхцөл байдалд хүргэж байна.

2.1 Хөдөлмөрт бэлтгэх хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох хөтөлбөр үр дүнтэй байна уу?

Үр чадвартай багш бүхий сургалтын төвүүдийг орон нутагтаа бий болгосноор хөдөлмөр эрхлэлтийг дэмжихээр байна.

Уг хөтөлбөрийн зорилго нь иргэдийг хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ болон хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох сургалтад хамруулж хөдөлмөрийн зах зээлд бэлтгэн, ажлын байранд дадлагажуулах замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэгджээ. Хөтөлбөрийн хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулсан байна. Үүнд:

-  Хөдөлмөрт бэлтгэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө
-  Хөдөлмөр эрхлэлтийн үр чадварын олгох сургалтад хамруулах

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө:

Хөтөлбөрийн хүрээнд бүлгийн сургалтад 1237 иргэн хамрагдаж ганцаарчилсан зөвлөгөө өгөх мэдээллээр 65 иргэн, 25 байгууллагыг ажил мэргэжлийн чиг баримжаа, зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамруулан нийт 10,310.0 мянган төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан бөгөөд хүүхэд, залуучууд, сургууль төгсөгчдийн ажил, мэргэжлээ сонгох ойлголт дээшилж, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээний хүртээмж сайжирсан байна.

Мэргэжил олгох сургалт:

Ажилгүй, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэнд тодорхой ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах мэргэжлийн чадамж бүхий харилцан уялдаатай нэгж ажилбаруудыг эзэмшүүлэх харилцааг зохицуулахад оршино.

Хөтөлбөрийн хүрээнд 2016 онд ажилгүй иргэд, ажил олгогчдын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн Улаанбаатар хотын “Замын төгрөг” сургалтын төв, “Ачит эверланд” сургалтын төв, аймгийн “Үнэлэмж” сургалтын төв зэрэг эрх бүхий байгууллагуудтай хамтран тогооч, оёдол,

жимс жимсгэнэ тариалах сургалтуудад 91 иргэнийг хамруулж сургалтын төлбөрт 11,701.3 мянган төгрөгийг ХЭДС-с зарцуулжээ. Дээрх иргэдийн 50 хувь буюу 45 хүн ажлын байртай хувиараа хөдөлмөр эрхэлдэг болоод байна. Тогоочийн сургалтад хамрагдсан иргэдийн 12 нь ажлын байртай болжээ.

ХХҮГ-аас зохион байгуулж буй Мэргэжил олгох сургалтад 2017 онд 84 иргэн хамрагдсан байна. Хөтөлбөрийн хүрээнд ажилгүй иргэд, ажил олгогчдын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн Улаанбаатар хотын “Сайн хүн” ТББ, “Төгс Ариун” ХХК, “Футур” сургалтын төв зэрэг эрх бүхий байгууллагуудтай хамтран тогооч, үсчин, оёдол, цэцэрлэгийн туслах багшийн сургалтуудад 13,700.0 мянган төгрөгийг ХЭДС-с зарцуулжээ.

Цаашид сургалтын төвүүдийг орон нутагтаа бий болгох, сургалтын багш нарыг чадавхжуулах, сургалтад хамрагдсан иргэдтэйгээ эргэх холбоотой байж ажлын байраар дэмжин, ажилд зуучилж байвал хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхээр байна. Хавсралт-13

2.2 Ажлын байрыг дэмжих хөтөлбөр үр дүнтэй хэрэгжиж байна уу?

Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 7 арга хэмжээг хэрэгжүүлсэн бөгөөд санхүүгийн дэмжлэгийг 2016 онд буцалтгүй нөхцөлөөр олгохдоо хамрагдсан иргэдийн 77 хувьд нь дунджаар 746.0 мянган төгрөг хуваарилж, төсөл хэрэгжүүлэх боломжийг нь хязгаарласнаар хөтөлбөрийн үр өгөөжийг бууруулах эрсдэл бий болгожээ.

Хувиараа болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр аж ахуй, бичил бизнес эрхлэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийг санхүүгийн болон бусад дэмжлэг, арга хэмжээнд хамруулж, байнгын ажлын байрыг хадгалах, ажил хайгч, оюутан, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагчийг түр ажлын байраар хангаж, орлого нэмэгдүүлэхэд ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн зорилго оршиж байна.

Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулсан байна. Үүнд:

- ✦ Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг
- ✦ Аж ахуй эрхлэлтийн сургалт
- ✦ Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн дэмжлэг үзүүлэх
- ✦ Ажил олгогчид дэмжлэг үзүүлэх
- ✦ Нийтийг хамарсан ажил зохион байгуулж, түр ажлын байраар хангах
- ✦ Ажил хайгч иргэд, оюутан, суралцагчдыг цагийн ажилд зуучилж орлого нэмэгдүүлэх
- ✦ Бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээг зохион байгуулж орлогын дэмжлэг үзүүлэх

Аж ахуй эрхлэх, бичил бизнесийг дэмжих хөтөлбөрт олгосон санхүүгийн дэмжлэг:

Хөтөлбөр нь аж ахуй бичил бизнес болон нөхөрлөл хоршооны хэлбэрээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид санхүү, эдийн засгийн болон бусад дэмжлэг үзүүлэх замаар ажлын байрыг бий болгох зорилготой.

ХХҮГ-т 2016 онд хувиараа аж ахуй, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй 35 болон түүнээс дээш насны иргэдийн 141 төсөл ирүүлснээс 96 иргэнд 97,500.0 мянган төгрөгийн санхүүгийн буцалтгүй дэмжлэгийг олгожээ.

Хөтөлбөрт нэг иргэнд 3.0 хүртэл сая төгрөгийн гарааны санхүүгийн дэмжлэг олгохоор заасан ч ХХҮГ нь төсөл ирүүлсэн иргэн бүрийг хамруулах чиглэлээр 96 иргэнд олгосон байна. Энэ нь олон хүнийг хамруулсан боловч нэг талаараа нэг иргэнд бага хэмжээний дэмжлэг олгосноор санхүүгийн дэмжлэг нь төсөл хэрэгжүүлэх боломжийг хязгаарласан байна. /Хавсралт-14/

Харин хөтөлбөр нь 2017 онд 100 хувь эргэн төлөх нөхцөлтэй болсон бөгөөд 2017 оны ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлтэй 35 дээш насны иргэдээс 50 төсөл ирүүлсэн байна. Үүнээс хяналт үнэлгээний дүнд үндэслэн хэрэгжих боломжтой 39 төсөлд 87,000.0 мянган төгрөгийг олгож 39 ажлын байр бий болгожээ.

Дэмжлэгт хамрагдсан иргэдийн ажлын байртай биеэр очиж танилцахад ажлын байр тогтворжиж, үйл ажиллагаа нь хэвийн явуулж байгаа нь сайшаалтай байна.

Бүлгийн зохион байгуулалттай хүнсний ногоо тариалах:

Уг арга хэмжээний хүрээнд ХХҮГ нь 2016 онд дараах ажлыг зохион байгуулжээ. Үүнд:

- ✦ Өөрийн байгууллагын эзэмшлийн 0.5 га газар дээр 3 улирлын хүнсний ногооны хүлэмж, амралтын байрыг барьж ашиглалтад оруулах тендер зарласан бөгөөд тус тендерт хамгийн бага үнийн санал ирүүлсэн, мөн гүйцэтгэх чадварыг нь харгалзан үзэж “Айргийн хад” ХХК-ыг шалгаруулж 19,463.9 мянган төгрөгөөр гэрээ байгуулж гүйцэтгүүлэн уг ажлыг хүлээн авсан байна.
- ✦ Инженерийн хийцтэй гүний худаг гаргах тендер зарлан, шалгаруулж “Ус-Алтай” ХХК-тай 18,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулан 2016 ондоо худгийн ажлыг хүлээн авч ашиглалтад оруулсан байна.

Хийгдсэн ажлуудыг газар дээр нь очиж үзэхэд стандарт зориулалтын дагуу чанартай баригдсан байлаа. Мөн хүлэмж, тариалангийн талбайд хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах мэргэжил олгох сургалтын дадлага ажлыг зохион байгуулж 23 иргэнд шаардлагатай ур чадварыг олгосон нь үр дүнгээ өгсөн ажил болсон төдийгүй сургалтад хамрагдсан иргэдээс 6 өрхийг сонгон тус хүлэмжид 1 жилийн хугацаатай гэрээ байгуулан ажиллуулсан байна.

Харин 2017 онд дахин хүлэмж бариулахаар тендер зарлахад “Тээвэрчин Алтай” ХХК үнийн санал ирүүлж 3 улирлын хүлэмжийг 18,752.0 мянган төгрөгөөр гүйцэтгүүлж, 2018 оны 3 сарын 1-нд хүлээн авахаар гэрээ байгуулсан байна. Гэрээний хугацаанд гүйцэтгэгч компаниас хугацаа сунгах хүсэлт ирүүлсний дагуу ХХҮГ-аас 2018 оны 5 сарын 25-нд хүртэл сунгахаар албан тоотоор мэдэгдсэн боловч тухайн ажилтны ажлын хариуцлагагүй байдлаас хуулийн дагуу гэрээнд өөрчлөлт оруулаагүй байна. /Хавсралт-15/

Ажил олгогчийг дэмжих арга хэмжээ:

Ажил олоход хүндрэлтэй иргэдийг байнгын зохистой ажлын байраар хангасан ажил олгогчдод болон ажилд орсон иргэдэд урамшуулал, сургалтын зардал, цалингийн дэмжлэгийн зардлыг бүрэн буюу хэсэгчлэн ХЭДС-гаас олгох ажлын хүрээнд 2016 онд 6 сараас дээш хугацаагаар бүртгэлтэй 7 иргэнийг байнгын тогтвортой ажлын байраар хангасан 5 ажил олгогчид 16,128.0 мянган төгрөгийн урамшууллыг олгосон бол 2017 онд 15 иргэнийг байнгын тогтвортой ажлын байраар хангасан 12 ажил олгогчид 34,560.0 мянган төгрөгийн урамшууллыг олгосон байна. Хавсралт-16

Ажлын байрны түрээс:

ХЭДС-гаас олгосон эргэн төлөгдөх санхүүгийн болон бусад дэмжлэг, бусад зээл авсан иргэний бараа, бүтээгдэхүүнийг борлуулахад дэмжлэг үзүүлэх, ажлын байрны түрээсийн хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Түрээсийн хөнгөлөлтийг жилд 6 сар хөнгөлөх бөгөөд тухайн сарын төлбөрийн 40 хувийг хөнгөлнө гэж гэрээнд заасны дагуу 2016 онд 20 иргэн түрээсийн хөнгөлөлтөд хамрагдаж 9,084.0 мянган төгрөгийн, 2017 онд 9 иргэн хамрагдаж 5,227.2 мянган төгрөгийн хөнгөлөлт эдэлсэн байна. Хавсралт-17

Нийтийг хамарсан ажил:

Арга хэмжээний хүрээнд 2016 онд давхардсан тоогоор нийт 12 суманд 314 иргэн нийтийг хамарсан ажилд оролцсон байна. Эдгээр иргэдийг өдрийн 24.0 мянган төгрөгөөр цалинжуулж нийт 33,946.4 мянган төгрөгийн зарцуулсан байна. Нийгмийн даатгалын хэлтэс дээр очин Нийтийг хамарсан ажилд оролцсон иргэдийг регистрийн дугаараар шүүж үзэхэд нийгмийн даатгалд хамрагдсан ажил эрхэлдэг иргэн байсангүй.

2017 онд давхардсан тоогоор нийт 30 суманд 570 иргэн нийтийг хамарсан ажилд оролцсон. Эдгээр иргэдийг өдрийн 28.0 мянган төгрөгөөр цалинжуулж нийт 151,662.2 мянган төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан байна. Нийтийг хамарсан ажилд оролцсон иргэдийг түүвэрчлэн Нийгмийн даатгалын хэлтэс дээр очин

регистрийн дугаараар шүүж үзэхэд ажил хөдөлмөр эрхэлж, нийгмийн даатгалд хамрагдаагүй байлаа. Мөн санхүүгийн баримтаас нийтийг хамарсан ажилд оролцон иргэдийн тоо, цагийн бүртгэл, урамшуулал авсан жагсаалт, гарын үсэг зэргийг тулгаж үзсэн.

Уг арга хэмжээний хүрээнд зөрчилтэй асуудал илрээгүй болно. Хавсралт-18

2.3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр үр дүнтэй хэрэгжсэн үү?

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд дэмжлэгийг хэт багаар олгосон нь ажлын байр бий болгосон хэдий ч үр дүнгээ өгсөн гэж үзэхэд хүндрэлтэй байна.

Хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрт бэлтгэх, дэмжлэгтэйгээр ажилд зуучлах, тэдний аж ахуй эрхлэлт болон хөдөлмөр эрхлэх ур чадвар олгох сургалтад хамруулах, урамшуулал, санхүүгийн дэмжлэг, хөдөлмөр эрхлэлтийн тусгай үйлчилгээ, арга хэмжээнд хамруулж дэмжлэг үзүүлэх замаар хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан байнгын ажлын байрыг нэмэгдүүлэх, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилготой.

Хувиараа болон бүлэг, нөхөрлөл, хоршооны хэлбэрээр өрхийн үйлдвэрлэл, аж ахуй, бичил бизнес эрхлэх хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих зорилгоор 2016 онд 45 иргэнд 39,000.0 мянган төгрөгийг эргэн төлөгдөх нөхцөлгүйгээр, 2017 онд 20 иргэнд 30,000.0 мянган төгрөгийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр санхүүгийн дэмжлэг олгожээ.

ХЭҮЗ-ийн 2015 оны 09 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн 3 дугаар зүйлийн 3.3.1 дахь заалт³-д заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төслийг сонгон шалгаруулалтыг үзэхэд нэг ажлын байранд 1,000.0 мянган төгрөгөөр тооцож, 5,000.0 хүртэл мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгохоор заасан боловч дэмжлэг авсан иргэдэд 500.0 мянгаас 2,000.0 мянган төгрөгийн дэмжлэг өгсөн нь хөтөлбөрт заасан нөхцөлийг зөрчсөн үйл ажиллагаа болсон байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төслийг 2016 онд сонгон шалгаруулалт хийсэн баримт материал аудитад хамрагдсангүй.

Төсөлд хамрагдсан иргэд нь эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэртэй байх, дангаараа болон бусадтай хамтран аж ахуй, бизнесийн төсөлтэй байх, аймгийн хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлж, хөтөлбөрт хамрагдах хүсэлтээ бичгээр илэрхийлсэн байх зэрэг шалгуурыг бүрэн хангасан байна. Хавсралт-19, 20

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гарч буй бэрхшээлтэй асуудлыг дурдвал:

- ✚ Санхүүгийн дэмжлэгт хамрагдах иргэдийн нэг ажлын байранд ногдох санхүүжилтийг багасгаж, олон иргэдэд хүртээх зорилгоор олгосон нь бодит хэрэгцээг хангаж чадаагүй.
- ✚ Нэг ажлын байрыг 1,000.0 мянган төгрөгөөр тооцсон нь төв суурин газарт жижиг зээл олгож ажлын байр бий болгож байгаа бодит тооцоотой нийцэхгүй байна.
- ✚ Хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд шинэ технологийн сургалт, зөвлөгөө мэдээллээр хангах үйлчилгээ үзүүлэгч мэргэшсэн байгууллага, төвүүд орон нутагт байхгүй байна.

2.4 Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх хөтөлбөр үр дүнтэй хэрэгжсэн үү?

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх хөтөлбөр үр дүнтэй хэрэгжсэн байна.

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ хэрэгжүүлэх хөтөлбөр нь МУ-ын ЗГ-ын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд заасан зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд өсвөр хойч залуу үеийнхэнд хөдөлмөрийн хүмүүжил олгох, мэдлэг, туршлагыг өвлүүлэх ахмад мэргэжилтнүүдийн сүлжээ, баг ажиллуулж, тэдгээрийн орлогыг нэмэгдүүлэхэд ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ хэрэгжүүлэх зорилготой.

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний хүрээнд аж ахуй эрхлэх, нөхөрлөл хоршоо, бүлэг байгуулж, үйлдвэрлэл эрхлэх, бизнесийн эхлэл, санаачилга хэрэгжүүлэхэд нь аж ахуй эрхлэлтийн сургалт үйлдвэрлэл үйлчилгээний зохион байгуулалтын чиглэлээр иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгөх зөвлөн туслах, мэдээлэл өгөх, өөрсдийн туршлагыг бусдад түгээн дэлгэрүүлэх зорилготой орон нутгийн тэтгэврийн насны 38 ахмад мэргэшсэн зөвлөхтэй хамтран ажиллаж гэрээ байгуулан 7,620.0 мянган төгрөгийн санхүүжилтийг ХЭДС-гаас олгосон байна.

³ Аймаг, дүүргийн Хөдөлмөрийн хэлтэс нь хувиараа болон бүлэг, нөхөрлөл, хоршооны хэлбэрээр өрхийн үйлдвэрлэл, аж ахуй, бичил бизнес эрхлэх хөгжлийн бэрхшээлтэй иргэний төслийг сонгон шалгаруулж, нэг ажлын байранд 1.0 сая төгрөгөөр тооцож, 5.0 хүртэл сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгоно.

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд 2017 онд 2 жилийн хугацаатай хүүгүй зээл олгох замаар тэднийг ажлын байраар хангах арга хэмжээг зохион байгуулжээ. Тус арга хэмжээнд хамрагдахаар 21 ахмад төсөл ирүүлснээс 8 төслийг сонгон шалгаруулж 7,500.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгон 8 ажлын байрыг бий болгожээ. Мөн залуу хойч үедээ зөвлөн туслах, өөрсдийн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилготой орон нутгийн тэтгэврийн насны 31 ахмад, ахмадын бүлгийн төсөлд 14,000.0 мянган төгрөгийг олгосон байна. Хавсралт-22

2.5 Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр үр дүнтэй хэрэгжсэн үү?

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр үр дүнтэй хэрэгжиж байна.

ХЭҮЗ-ийн 2015 оны 9 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, 2017 оны 1 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр” батлагдаж 2016, 2017 онд уг хөтөлбөрүүдийг мөрдөж ажиллажээ.

Уг хөтөлбөрийн хүрээнд 2016 онд хэрэгжүүлэх арга хэмжээ:

- ✚ Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгч болон төгсөгчдийн бүлэгт санхүүгийн дэмжлэг олгох
- ✚ Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчид инкубацийн үйлчилгээ үзүүлэх
- ✚ Оюутан суралцагчдыг цагийн ажилд зуучлах

2017 онд хэрэгжүүлэх арга хэмжээ

- ✚ Гарааны бизнесийг дэмжих
- ✚ Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох
- ✚ Борлуулалтын болон үйлдвэрлэлийн ажлын байрны түрээсийн хөнгөлөлт олгох

Дээрх арга хэмжээний хүрээнд 2016 онд хөтөлбөрт заасан шаардлагыг хангасан 25 хүртэлх насны мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг төгссөн 10 иргэнд нийт 20,000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг буцалтгүй олгосон байна. Санхүүгийн дэмжлэг авсан иргэдтэй биечлэн уулзаж үйл ажиллагаатай танилцахаар төлөвлөсөн ба 4 төсөл хэрэгжүүлэгчтэй биечлэн уулзахад үйл ажиллагаа явуулж байлаа. Харин 2 иргэн цэрэгт явсан, 1 иргэн хөдөө сумд үйл ажиллагаа явуулдаг, 2 иргэн хөдөө ажлаар явсан, 1 иргэн төрж амаржсан байна. ХЭҮЗ-өөс баталсан хөтөлбөрт иргэн төсөлд хамрагдсанаас хойш хэдий хугацаанд үйл ажиллагаа тогтвортой явуулахыг тусгаж өгөөгүйгээс дэмжлэг авсан иргэд цаашид үйл ажиллагаагаа явуулахгүй зогсоож, хөтөлбөрийн үр дүнг бууруулах эрсдэлтэй байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчид инкубацийн үйлчилгээ үзүүлэх, оюутан суралцагчдыг цагийн ажилд зуучлах үйлчилгээ хийгдээгүй байна.

ХЭҮЗ-ийн 2017 оны 1 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”-ийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь заалт⁴-д эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг нь 24 сарын хугацаанд буцаан төлүүлэх нөхцөлтэй болж өөрчлөгдсөн бөгөөд 2017 онд хөтөлбөрт заасан шаардлагыг хангасан 24 хүртэлх насны 13 иргэнд 30,000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгосон байна. Мөн эдгээр дэмжлэг авсан иргэдээс аймгийн төвд байршилтай 4 иргэнтэй биечлэн уулзахад бүгд үйл ажиллагаа явуулж байлаа. 1 иргэн гачигдлаар Улаанбаатар хотод, 7 иргэн хөдөө сумд, 1 иргэн төрж амаржсан учраас үйл ажиллагаатай танилцаагүй.

“Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгч, төгсөгчийн бүлэгт эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэг олгох гэрээ”-ний 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт⁵-ын дагуу

⁴ Төгсөгч болон бүлэг нь гэрээ байгуулснаас хойш 24 сарын дотор санхүүгийн дэмжлэгийг эргүүлэн төлөх ба эргэн төлөлтийн хуваарийг төгсөгч, бүлгийн саналыг харгалзан тогтооно.

⁵ А тал нь В талын тоног төхөөрөмж багаж хэрэгсэл худалдан авч ажлын байр бий болгохыг дэмжих зорилгоор санхүүгийн дэмжлэгийг Б талын дансанд шилжүүлэх бөгөөд тухайн санхүүгийн дэмжлэгийг 100 хувь хөрөнгө дансанд шилжиж орсноос хойш 24 сарын дотор Б тал хавсралтанд тусгасан эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлж

зээлийн эргэн төлөлтийг шахаж тооцоход гэрээний хугацаа дуусаагүй хэдий ч эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөх төлбөрөөс 1,502.0 мянган төгрөгийг хугацаанд нь төлүүлээгүй байна. Гэрээт хугацаанд төлөөгүй мөнгөн дүнг тооцохдоо Төрийн аудитын байгууллагаас ХЭДС-гийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 2,646.2 мянган төгрөгийн төлбөрийн актыг хасаж тооцсон бөгөөд уг төлбөрийн актаас 2,296.2 мянган төгрөг төлөгдөж, хэрэгжээгүй шийдвэрийн үлдэгдэл 350.0 мянган төгрөг байна. Гэрээт хугацаанд төлөгдөөгүй төлбөрийг бүрэн төлүүлэх шаардлагатай байна.

Мөн тус гэрээг байгуулахдаа ХХҮЕГ-ын даргын 2017 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн А/63 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт ХЭДХ-ийн гэрээний загвар-8 "Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгч, төгсөгчдийн бүлэгт эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэг олгох гэрээний загвар"-ын 3 дугаар зүйлийн 3.9 дэх заалт /Нийгмийн даатгалын сайн дурын эсвэл заавал даатгалд хамрагдсан байна/-ыг орхигдуулсан бөгөөд төсөлд хамрагдсан 13 иргэнээс 11 иргэн нийгмийн даатгалд огт хамрагдаагүй байна. Энэ нь гэрээний загварыг зөрчиж гэрээ байгуулснаас үүссэн байх магадлалтай бөгөөд нөгөө талаараа төслийн үр дүнд сөргөөр нөлөөлж байна. Иймд гэрээг батлагдсан загварын дагуу байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллах нь зүйтэй.

Санхүүгийн дэмжлэгт 2016 онд хамрагдсан 8 төгсөгчийг бизнесээ эхлүүлэх төсөл бичих аж ахуй эрхлэх сургалтад хамруулан 240.0 мянган төгрөгийг зарцуулсан. 2017 онд дахин сургалт зохион байгуулан 1,500.0 мянган төгрөг зарцуулсан байна.

ХЭҮЗ-ийн 2017 оны 1 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”-ийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалт⁶-д заасан шаардлагыг үндэслэн борлуулалтын болон үйлдвэрлэлийн ажлын байрны түрээсийн хөнгөлөлт олгох арга хэмжээний хүрээнд 2016-2017 онд санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 4 иргэнийг түрээсийн хөнгөлөлтөд хамруулж 1,411.2 мянган төгрөг олгосон байна. /Хавсралт-23/ Гарааны бизнесийг дэмжих арга хэмжээ 2017 онд хэрэгжээгүй байна.

2.6 Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр үр дүнгээ өгсөн үү?

Хөтөлбөрт хамрагдсан 200 малчин өрхөөс 192 өрхийн малын тоо дунджаар 3.9 дахин өсөж үр дүнгээ өгсөн байна.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр 2014 оноос хойш жил бүр тасралтгүй хэрэгжиж байгаа бөгөөд ХЭҮЗ-ийн 2015 оны 9 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар батлагдсан “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, 2017 оны 1 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд малчин өрхийг малжуулах болон мал маллагааны арга ажиллагаа, аж ахуй эрхлэлтийн сургалт, туршлага солилцох уулзалт зохион байгуулах гэсэн 2 арга хэмжээг зохион байгуулахаар байна.

Малчин өрхийг малжуулах арга хэмжээний талаар:

ХЭДС-гаас 2016 онд 60 малчин өрхийг 269,800.0 мянган төгрөгийн малаар, 2017 онд 40 малчин өрхийг 185,000.0 мянган төгрөгийн малаар малжуулсан байна. Хүснэгтээр дэлгэрүүлж харуулбал:

барагдуулахаар тохиролцов/, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 онд баталсан "Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр"-ийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь заалт /Төгсөгч болон бүлэг нь гэрээ байгуулснаас хойш 24 сарын дотор санхүүгийн дэмжлэгийг эргүүлэн төлөх ба эргэн төлөлтийн хуваарийг төгсөгч, бүлгийн саналыг харгалзан тогтооно

⁶ Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар 6 болон түүнээс дээш сарын хугацаагаар байнгын ажлын байр түрээслэн үйл ажиллагаа явуулж байгаа бол түрээсийн гэрээ, холбогдох баримт бичиг, нөхцөл байдлыг газар дээр нь үнэлсэн үнэлгээнд үндэслэн ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг төлбөр төлсөн баримтаар нөхөн олгоно.

Малжуулах арга хэмжээний талаарх мэдээлэл

Огноо	Хөтөлбөрт зааснаар эргэн төлөх хувь	Хамрагдсан малчин өрхийн тоо	ХЭДС-гаас зарцуулсан хөрөнгө	Авлагын эхний үлдэгдэл	Тухайн онд авлага үүсгэсэн дүн	Төлсөн дүн	Хүснэгт №8 Авлагын эцсийн үлдэгдэл
2014	50 хувь	40	185,900.1	-	100,000.0	-	100,000.0
2015	50 хувь	60	264,100.0	100,000.0	132,050.0	-	232,050.0
2016	50 хувь	60	269,800.0	232,050.0	134,900.0	26,950.0	340,000.0
2017	100 хувь	40	185,000.0	340,000.0	185,000.0	161,180.0	363,820.0
2018				363,820.0		147,205.0	216,615.0

Жил бүр хөтөлбөрт заасан эргэн төлөлтийн хувийг үндэслэн малчдаас авах авлагыг зөрүүгүй үүсгэж 2018 оны 5 сарын байдлаар 216,615.0 мянган төгрөгийн авлагатай байна.

Тус хөтөлбөрийн 2 дугаар зүйлийн 2.2.1 дэх заалт⁷-д хөтөлбөрт хамрагдах малчны ерөнхий шаардлагыг зааж өгсний дагуу тулган баталгаажуулахад 2016, 2017 онд шаардлагад бүрэн нийцсэн малчдыг хамруулсан нь сайшаалтай байна. Хөтөлбөрийн 2 дугаар зүйлийн 2.2.4 дэх заалт⁸-д заасны дагуу амьжиргааг дэмжих зөвлөлийн саналыг үндэслэн малчин өрхийг сонгосон байна. Харин гэрээ болон эргэн төлөлтийн хуваарьтай холбоотой зөрчил илэрсэн. /Хавсралт-24/ Үүнд:

- ✚ Хөтөлбөрийн хүрээнд 2016 онд 60 өрхийг малжуулан "Малчин өрхийг малжуулах гэрээ" байгуулахдаа 44 малчны "Эргэн төлөлтийн хуваарь" огт хийж баталгаажуулаагүй, 16 малчны эргэн төлөлтийн хуваарийг хийсэн боловч гэрээний дүнгээс 1,900.0 мянган төгрөгөөр илүү тусгажээ. Эргэн төлөлтийн хуваарь нь 2017 онд жигд адилхан байгаагаас үзэхэд зээлийн эргэн төлөлтийн хуваарийг хийхдээ иргэний саналыг тусгаагүй байна.
- ✚ Хөтөлбөрт хамрагдсан малчин өрхөөс 14 малчин өрхтэй байгуулсан гэрээний огноо тодорхойгүй, малыг актаар хүлээлгэн өгсөн хэдий ч 8 гэрээнд малчин өрхөд хүлээлгэн өгсөн малын тоо тодорхойгүй байна.

Харин хөтөлбөрт хамрагдсан малчид төсөл төлөвлөгөөг бүрэн ирүүлжээ.

Хөтөлбөрийн 2 дугаар зүйлийн 2.2.6 дахь заалт⁹-д заасны дагуу 50 хүртэл толгой малтай өрхийг малжуулахдаа дадлагажуулагч малчинг харгалзан үзсэн эсэхийг судлахад 2016-2017 онд 50 хүртэл толгой малтай 13 малчин өрхийг малжуулахдаа 4 өрхийн дадлагажуулагч малчинтай гэрээ байгуулан, 9 малчин өрхийг дадлагажуулагч малчинтай эсэхийг харгалзаж үзээгүй байна. Иймд малчин өрхтэй гэрээ байгуулахдаа хариуцлагатай хандаж гэрээний хугацааг бүрэн гүйцэд тавьж, гэрээнд тусгасан тоон мэдээлэл үнэн зөвийг нягталж, эргэн төлөлтийн хуваарийг хийхдээ малчин өрхийн саналыг харгалзах шаардлагатай байна. Гэрээ болон эргэн төлөлтийн хуваарьтай холбоотой дээрх зөрчлүүд нь ХХҮГ болон малчин өрхийн хооронд маргаан үүсгэх эрсдлийг бий болгож байна.

Хөтөлбөрийн 2 дугаар зүйлийн 2.2.5 дахь заалт¹⁰-д мал худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулна гэж заасан. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1

⁷ Малчин өрхийг малжуулах арга хэмжээнд хөдөлмөрийн чадвартай, 15-39 насны /35 хүртэл насны/ 2-оос доошгүй гишүүнтэй, бог малд шилжүүлснээр 200 /150/ хүртэл толгой малтай малчин өрхийг хамруулна.

⁸ Арга хэмжээнд хамрагдах малчин өрхийг сумын Амьжиргааг дэмжих зөвлөлийн саналыг үндэслэн аймаг нийслэлийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс сонгож, гэрээ байгуулж ажиллах бөгөөд гэрээнд эргэн төлөлтийн хуваарийг иргэний хүсэлтийг үндэслэн тогтоосон байна. Хамрагдах малчин өрх нь төлөвлөгөө, төсөлтэй байна.

⁹ Хэрэв 50 хүртэл толгой малтай малчин өрх малжуулах арга хэмжээнд хамрагдах бол мал аж ахуй эрхлэх дадлага, туршлагатай дадлагажуулагч малчинтай байна.

¹⁰ Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь мал худалдан авч өгөх үйл ажиллагааг хуулийн дагуу нээлттэй, ил тод зохион байгуулна. Худалдан авч байгаа малын үнэ нь зах зээлийн дундаж үнээс илүүгүй байна.

дэх заалт¹¹, 8 дугаар зүйлийн 8.7.1 дэх заалт¹² болон Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолын хавсралт "ТБОНӨХБАҮХА ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ"-ийг баримталбал мал худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын журмыг сонгож явуулахаар байна. Гэтэл 2016 онд 269,800.0 мянган төгрөгийн мал, 2017 онд 185,000.0 мянган төгрөгийн мал худалдан авахдаа сум бүрээс жигд үнээр буюу зах зээлийн жишиг үнээр авсан боловч зохих худалдан авах ажиллагааны журмыг баримтлалгүйгээр шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хууль болон ХЭҮЗ-ийн баталсан журмыг зөрчсөн үйлдэл болж байгаа тул худалдан авах ажиллагааг хуулийн дагуу явуулах шаардлагатай байна.

Мөн аудитаар 2016, 2017 оны үйл ажиллагааг хамруулан үзсэн хэдий ч 2014, 2015 онд малжуулах хөтөлбөрт хамрагдсан малчдын зээлийн эргэн төлөлт аудитын хамрах хугацаанд хамаарч байгаа тул зээлийн эргэн төлөлтийн судалгааг 2014-2017 онд тус хөтөлбөрт хамрагдсан нийт 200 малчныг хамруулж хийлээ. Хөтөлбөрийн 2 дугаар зүйлийн 2.2.4 дэх заалт¹³-д эргэн төлөлтийн хуваарийг иргэний хүсэлтийг үндэслэн тогтоосон байна гэж заасны дагуу гэрээ болон эргэн төлөлтийн хуваарийг харгалзан тооцоход:

- ✚ Малчин өрхтэй байгуулсан гэрээний хугацаа дууссан байхад 17,040.0 мянган төгрөгийн эргэн төлөлтийг хийлгээгүй байна.
- ✚ Малчин өрхтэй байгуулсан гэрээний хугацаа дуусаагүй хэдий ч эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөх төлбөрөөс 12,984.5 мянган төгрөгийг хугацаанд нь төлүүлээгүй байна.

Энэ нь ХЭДС-гийн хөрөнгийн эргэцийг удаашруулах, найдваргүй авлага нэмэгдүүлэх, хөтөлбөрийн үр өгөөжийг бууруулах эрсдэлийг бий болгож байгаа тул холбогдох малчин өрхөд мэдэгдэх хуудас хүргэх замаар гэрээний хугацаа дууссан болон гэрээт хугацаанд төлөгдөөгүй авлагыг төлүүлэх шаардлагатай байна.

Мал маллагааны арга ажиллагаа, аж ахуй эрхлэлтийн сургалт, туршлага солилцох уулзалтын талаар:

ХЭҮЗ-ийн 2015 болон 2017 онд баталсан “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг 2 арга хэмжээгээр зохион байгуулах бөгөөд хөтөлбөрийн 2 дугаар зүйлийн 2.1.2 дахь заалт¹⁴ болон 2.3 дахь заалт¹⁵-д малын эрүүл мэнд, мал маллах арга ажиллагааны болон малын ашиг шимийг боловсруулах, туршлага солилцох уулзалт зохион байгуулах, малын хашаа хороо барих, хадлан тэжээл, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зэрэг дэмжлэг үзүүлэх, ба энэхүү арга хэмжээ нь ХЭДС-гаас уг хөтөлбөрт хуваарилагдсан нийт хөрөнгийн 5 хувиас ихгүй байхаар заажээ. Гэтэл 2016, 2017 уг арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

Малчин өрхийг малжуулах арга хэмжээний гэрээнд мал маллагааны арга ажиллагаа, аж ахуй эрхлэлтийн сургалт, туршлага солилцох уулзалтыг зохион байгуулан дэмжиж ажиллана гэж заасан боловч арга хэмжээг зохион байгуулаагүй нь тус гэрээ болон хөтөлбөрийг зөрчсөн үйлдэл болжээ. Цаашид ХЭДС-гаас зохих хөрөнгийг уг арга хэмжээнд зарцуулж, хөтөлбөр болон малчин өрхтэй байгуулсан гэрээний дагуу сургалт, туршлага солилцох уулзалт зохион байгуулах нь зүйтэй байна.

Хөтөлбөрийн үр дүнгийн талаар:

Хөтөлбөрийн 3 дугаар зүйлд хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг тодорхойлсон байна. Үүний дагуу 2014-2017 онд малжуулах хөтөлбөрт хамрагдсан малчдын 2017 оны жилийн эцсээр тоолуулж баталгаажуулсан малын тоог хөтөлбөрт хамрагдахаас өмнө тоолуулсан малын тоотой харьцуулж үр дүнг тооцож дараах байдлаар харууллаа.

¹¹ нээлттэй тендер шалгаруулалтын журам

¹² Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгох

¹³ Арга хэмжээнд хамрагдах малчин өрхийг сумын Амьжиргааг дэмжих зөвлөлийн саналыг үндэслэн аймаг нийслэлийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс сонгож, гэрээ байгуулж ажиллах бөгөөд гэрээнд эргэн төлөлтийн хуваарийг иргэний хүсэлтийг үндэслэн тогтоосон байна. Хамрагдах малчин өрх нь төлөвлөгөө, төсөлтэй байна.

¹⁴ Мал маллагааны арга ажиллагаа, аж ахуй эрхлэлтийн сургалт, туршлага солилцох уулзалт, арга хэмжээг зохион байгуулах

¹⁵ Мал аж ахуй эрхлэлтийн сургалт, туршлага солилцох уулзалт, арга хэмжээг зохион байгуулах

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн үр дүн

Хүснэгт №9

Хөтөлбөрт хамрагдсан он	Малчин өрхийн тоо	Малын тоо /2017 оны жилийн эцсийн А дансаар/				Шилжсэн, буцаасан
		Өссөн		Буурсан		
		Малчин өрхийн тоо	Дунджаар	Малчин өрхийн тоо	Дунджаар	
2014	40	35	3.6 дахин өссөн	3	1.9 дахин буурсан	2
2015	60	58	5.2 дахин өссөн	2	1.6 дахин буурсан	0
2016	60	59	4.5 дахин өссөн	1	2.4 дахин буурсан	0
2017	40	40	2.5 дахин өссөн	0	0	0
Нийт	200	192	3.9 дахин өссөн	6	2.0 дахин буурсан	2

Дээрх хүснэгтийн мэдээллээс харахад хөтөлбөрт хамрагдсан нийт малчин өрхийн 96 хувь буюу 192 өрхийн малын тоо дунджаар 3.9 дахин өссөн, 3 хувь буюу 6 малчин өрхийн малын тоо дунджаар 2.0 дахин буурсан үзүүлэлттэй байгаа нь хөтөлбөрийн үр дүнг сайн байгааг илтгэж байна. Хавсралт-25

Хөтөлбөрийн үр дүнг нөгөө талаар туршлага солилцох уулзалт болон сургалтуудыг зохион байгуулснаар ахмад, туршлагатай малчдаас суралцаж мал маллах арга ажиллагааны чадвар, мэдлэг дээшилсэн байдлаар үнэлсэн байхад 2016, 2017 онд туршлага солилцох уулзалт, сургалтуудыг зохион байгуулаагүй нь хөтөлбөрийн үр дүнг бууруулах эрсдэл бий болгож байна.

2.7 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөтөлбөрөөс бусад орлого, зарцуулалт үр ашигтай байна уу?

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

ХЭДС-гийн тухай хуулийн 22 дугаар зүйлд ХЭДС-гийн эх үүсвэрийг тодорхойлсон байна. Үүнд:

- ✚ Улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө
- ✚ Орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө
- ✚ ХЭДС-гийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү
- ✚ Гадаад улс, олон улсын байгууллагаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор олгосон зээл
- ✚ Гадаадын иргэнийг гэрээгээр ажиллуулсан ажил олгогчийн төлөх ажлын байрны төлбөр
- ✚ Гадаад улс, олон улсын байгууллага, Монгол улсын болон гадаад улсын аж ахуй нэгж байгууллага, төрийн бус байгууллага, иргэдээс ХЭДС-д оруулсан хандив тусламж
- ✚ ХБИ буюу одой хүнийг ажиллуулаагүй аж ахуй нэгж байгууллагаас төлөх төлбөр
- ✚ Жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөгдсөн хөрөнгө

ХЭДС нь улсын төсөв, орон нутгийн төсөв, жижиг зээл санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн хөрөнгөөс санхүүжиж байна.

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу төсөл хөтөлбөрүүдэд зарцуулсан байна.

Дэд зорилт-3: Сангийн үйл ажиллагаанд тавигдах хяналт оновчтой үр дүнтэй байна уу ?

Дотоод хяналт хийгдэж байгаа боловч ажлын тайлан хангалтгүй, нотлох баримтаар дэмжигдэхгүй байна.

3.1 Дотоод хяналтын систем оновчтой байж хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явц үр дүнд байнгын хяналт тавьж ажиллаж байна уу?

Хяналт хийх төлөвлөгөө батлуулж ажилласан хэдий ч цаашид хяналтыг чанартай зохион байгуулж, үр дүнг тайлагнаж байх шаардлагатай байна.

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2016 оны Б/21 дүгээр тушаалаар аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын бүтэц, орон тоог баталжээ. Уг тушаалаар хяналт- шинжилгээ, үнэлгээ хариуцсан 2 мэргэжилтэн томилогдсон байна.

Аудитад 2016 оны жилийн эцсийн хяналтын тайлан ирүүлээгүй ба 2016 оны 8 сарын 17-ны байдлаар бичсэн хяналтын тайлан ирүүлсэн. Уг баримт материалын хүрээнд 2016 онд хийгдсэн дотоод хяналтын ажлыг үзэхэд байгууллагын хамт олны хурлаар 2016 онд “Хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх ерөнхий төлөвлөгөө” баталсан бөгөөд тус төлөвлөгөөнд ХЭДС-д 10 чиглэлээр хяналт хийхээр оруулсан байна. Төлөвлөгөөний дагуу 8 чиглэлээр хяналт хийн дүгнэлт боловсруулж, үйл ажиллагааг сайжруулах талаар 27 заалттай зөвлөмж хүргүүлжээ.

Харин “Алтайд үйлдвэрлэв” дэлгүүрийн үйл ажиллагаа болон ХЭДС-гийн гүйцэтгэлд хяналт хийхээр төлөвлөсөн боловч хяналт хийгдээгүй орхигдсон байна.

Мөн 2017 онд ХХҮГ-ын даргаар “Говь-Алтай аймгийн ХХҮГ-ын 2017 онд хийж гүйцэтгэх хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө” батлуулсан бөгөөд тус төлөвлөгөөнд ХЭДС-гаас 2017 онд хэрэгжих төсөл хөтөлбөрүүд болон тэдгээрийн хэрэгжилтийн байдалд хяналт хийхээр ерөнхий 2 чиглэлээр оруулсан байна. Тус төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт хийсэн гэж тайлан бичсэн боловч энэ нь баримтаар нотлогдохгүй, шаардлага хангахгүй байна. Иймд дотоод хяналтын ажлыг сайжруулж, хяналтын төлөвлөгөөний биелэлтийг тодорхой хугацаагаар гаргаж ажиллах шаардлагатай байна.

3.2 Хяналт шалгалтын байгууллагуудын хяналтын шийдвэрийг хэрэгжүүлж ажилласан байна уу?

Хяналт шалгалтын байгууллагаас өгсөн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.

Төрийн аудитын байгууллагын хяналт, шалгалтын талаар:

Төрийн аудитын байгууллагаас 2014 онд “ХЭДС-гийн 2013 оны үйл ажиллагааны үр дүн”-д нийцлийн аудит хийсэн байна. Уг аудитаар 399,239.5 мянган зөрчил илэрч 84,968.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 297,188.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 17,082.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна. Хавсралт-26

Уг зөрчлүүдэд гаргасан шийдвэрээс албан шаардлага, зөвлөмж хугацаандаа буюу 2014 онд биелэгдсэн байна. Харин төлбөрийн актын тухайд 38,693.2 мянган төгрөгийн акт цуцлагдаж, 30,040.2 мянган төгрөг нь 2014 онд биелэгдэж, ХБИ ажиллуулаагүйн төлбөр, 52 ажилтай иргэдийг сургалтанд хамруулсан зөрчил болон нийтийг хамарсан ажилтай холбоотой нийт 16,235.3 мянган төгрөгийн төлбөрийн акт биелэгдээгүй байна. Уг акттай холбоотойгоор ХХҮГ-аас 2017 оны 8 сарын 7-ны 326 тоот албан бичгээр 52 ажилтны сургалттай холбоотой 6,100.0 мянган төгрөгийн актаас чөлөөлүүлэхийг хүссэн боловч төрийн аудитын байгууллага үндэслэл хангалтгүй байна гэж үзээд уг актыг хүчингүй болгоогүй байна.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг давтан гарсан эсэхэд судалгаа хийхэд:

- ✚ Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулаагүйн төлбөр төлүүлээгүй,
- ✚ Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэд нийгмийн даатгалд хамрагдаагүй байна.

Төрийн аудитын байгууллагаас аудит хийхдээ хууль тогтоомж, журам, стандартад нийцүүлж гүйцэтгэдэг бөгөөд илэрсэн алдаа, зөрчилд үндэслэн тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахаар зөвлөмж шийдвэр хүргүүлдэг. Иймд аудитаар өгсөн зөвлөмж

шийдвэрийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах нь алдаа, зөрчлийг бууруулж, үйл ажиллагааг сайжруулах сайн талтай юм.

Санхүүгийн тайлангийн аудитын тухайд 2016, 2017 онуудын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитыг авч үзлээ. 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй, харин 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар залруулга хийгдээгүй ба “Эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөгдвөл зохих 12,139.3 мянган төгрөгийн дэмжлэг эргэн төлөгдөөгүй” зөрчилд төлбөрийн акт тогтоогджээ. Бид аудитаар эдгээр санхүүгийн дэмжлэгүүдийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу шахаж тооцоход төлбөрийн актаас 9,734.8 мянган төгрөг биелэгдэж, төлөгдөөгүй үлдэгдэл 2,404.5 мянган төгрөг байна. Төлөгдөөгүй үлдэгдлийг барагдуулж ажиллах шаардлагатай байна.

Мэргэжлийн хяналтын газрын шалгалтын талаар:

Мэргэжлийн хяналтын байгууллагын 2017 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2017 оны 7 сарын 24-ны өдрийн баталсан 01/205 дугаартай урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын удирдамжийг үндэслэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Халамжийн сангийн 2015, 2016 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн байна. Хяналтаар дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- ✚ Эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэг хуваарьт хугацаанд төлөгдөөгүй.
- ✚ Ахмад мэргэжилтний зөвлөгөө өгөх үйлчилгээ үр ашиггүй хэрэгжсэн.
- ✚ Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын төгсөгчдийг дэмжих арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх нь тодорхойгүй.
- ✚ Аж ахуй эрхлэх, бичил бизнесийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн дэмжлэгийг хавтгайруулан олгосон, зориулалтыг өөрчилсөн, зориулалтын дагуу үйл ажиллагаа явуулаагүй.
- ✚ ХБИ-д олгож буй санхүүжилтийг хавтгайруулан олгосон, үйл ажиллагааны тайлан ирүүлээгүй бөгөөд шаардлага хангахгүй байсан.
- ✚ ХЭСЗ нь төсөл хөтөлбөр хэлэлцэхээс өөр ажил зохион байгуулаагүй.
- ✚ Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаа, хэтийн төлвийг гаргаагүй зэрэг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан арга хэмжээг хэрэгжүүлээгүй.
- ✚ Төсөл хөтөлбөрт тавих хяналт хангалтгүй гэсэн зөрчлүүд илэрчээ.

Дээрх зөрчлийн хүрээнд МХЕГ-т 3 заалт бүхий санал, ХЭСЗ-д 1 заалт бүхий санал, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газарт 6 заалт бүхий хугацаатай албан шаардлага хүргүүлсний хүрээнд ажлын төлөвлөгөө гарган ажиллаж дээрх зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллажээ.

Нийцлийн аудитаар биелэлтийг үзэхэд санхүүгийн дэмжлэг хуваарьт хугацаанд төлөгдөөгүй зөрчил болон ХЭСЗ-тэй холбоотой зөрчлийг эс тооцвол илэрсэн зөрчил давтагдан гараагүй бөгөөд хяналт шалгалтын үр өгөөж бий болжээ.

Санхүүгийн хяналт, аудитын албаны шалгалтын талаар:

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны 2016 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын 2016 оны үйл ажиллагаанд 2017 онд хяналт шалгалт хийжээ. Шалгалтаар ХЭДС-гаас хэрэгжсэн 5 төсөл хөтөлбөрийг түүвэрлэн үзсэн бөгөөд дараах зөрчил илэрчээ. Үүнд:

- ✚ Малчдад олгосон малын тоо статистик мэдээний малын тооноос 4 толгой малаар зөрүүтэй.
- ✚ Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан 2 иргэн төсөлд тусгагдсан тоног төхөөрөмж аваагүй, үйл ажиллагаа явуулаагүй
- ✚ Шилэн дансны цахим хуудсанд оруулсан мэдээлэл чанаргүй гэсэн зөрчил илэрчээ.

Дээрх зөрчлийг бүрэн арилгаж ажилласан бөгөөд Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдаж үйл ажиллагаа явуулаагүй 2 иргэн нь цэрэгт явсан болон төрж амаржсан шалтгаанаар үйл ажиллагаа явуулаагүй байна.

Илрүүлэлт:

Хөдөлмөр эрхлэлтийн дэд сан, ХЭСЗ-ийн үйл ажиллагааны хүрээнд:

1. Аймгийн Засаг даргын 2017 оны 1 сарын 23-ны А/11 захирамжаар ХЭСЗ байгуулахдаа хууль зөрчин ХХҮГ-ын даргыг зөвлөлийн гишүүнээр оруулсан бөгөөд 555.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.
2. ХЭСЗ нь үйл ажиллагаа явуулахдаа зөвлөлийн дүрэмд тусгагдсан чиг үүргүүдийг орхигдуулж байна. Мөн дүрэмд зааснаар зөвлөлийн дарга нь аймгийн Засаг дарга байхад Засаг даргын орлогч зөвлөлийн даргаар ажиллаж байна.

Төсөл сонгон шалгаруулалтын хүрээнд:

3. Хөтөлбөрт хамрагдахаар иргэдийн ирүүлсэн төслийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг амаар тайлбар хийж байгаа боловч баримтаар баталгаажуулаагүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй төлбөрийн хүрээнд:

4. ХХҮГ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн, одой хүний нэгдсэн судалгааг нэр төдий гаргасан бөгөөд аудитын хийсэн судалгаанаас зөрүүтэй байна. Аудитаар байгууллагууд түүвэрлэн үзэхэд 2016-2018 оны 5 дугаар сарын байдлаар ХБИ ажиллуулаагүйн 49,716.0 мянган төгрөгийн төлбөрийг төлүүлээгүй байна.
5. Төрийн аудитын байгууллагаас Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор 2014 онд ХЭДС-д хийсэн аудитаар ХБИ ажиллуулаагүйн төлбөр төлүүлээгүй 48,439.0 мянган төгрөгийн зөрчилд шийдвэр гаргаснаас 9,745.8 мянган төгрөг одоог хүртэл биелэгдээгүй, дараа нь 2015 онд ХЭДС-гийн Санхүүгийн тайлангийн аудитаар тус сангийн эх үүсвэрийн орлого ХБИ ажиллуулаагүйн төлбөр 20,000.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн боловч тухайн орлого тасарсан зөрчилд шийдвэр гаргасан нь биелээгүй, мөн ХЭДС-гийн 2016-2017 оны үйл ажиллагааг хамарч гүйцэтгэсэн аудитаар байгууллагуудыг түүвэрлэн үзэж судалгаа хийхэд ХБИ ажиллуулаагүйн 49,716 мянган төгрөгийн төлбөрийг төлүүлээгүй бөгөөд уг зөрчил жил бүр давтагдан гарсаар байна.

ХЭҮЗ-ийн баталсан хөтөлбөрүүдийн хүрээнд:

6. Малчин өрхтэй байгуулсан гэрээний хугацаа дууссан байхад 17,040.0 мянган төгрөгийн эргэн төлөлтийг хийлгээгүй байна.
7. Хувиараа хөдөлмөр эрхлэгч нөхөрлөл хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2015 онд 50 хувь эргэн төлөгдөх нөхцөлөөр олгосон санхүүгийн дэмжлэгийн хугацаа дууссан боловч 2,372.9 мянган төгрөгийг төлүүлээгүй байна.
8. Малчин өрхтэй байгуулсан гэрээний хугацаа дуусаагүй хэдий ч эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөх төлбөрөөс 12,984.5 мянган төгрөгийг хугацаанд нь төлүүлээгүй байна.
9. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2016 онд 60 өрхийг малжуулан "Малчин өрхийг малжуулах гэрээ" байгуулахдаа 44 малчны "Эргэн төлөлтийн хуваарь" огт хийж баталгаажуулаагүй, 16 малчны эргэн төлөлтийн хуваарийг хийсэн боловч гэрээний дүнгээс 1,900.0 мянган төгрөгөөр илүү тусгажээ.
10. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан малчин өрхөөс 14 малчин өрхтэй байгуулсан гэрээний огноо тодорхойгүй, малыг актаар хүлээлгэн өгсөн боловч 8 гэрээнд малчин өрхөд хүлээлгэн өгсөн малын тоог тавьж өгөөгүй байна.
11. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 50 хүртэл толгой малтай 13 малчин өрхийг малжуулахдаа 4 өрхийн дадлагажуулагч малчинтай гэрээ байгуулан, 9 малчин өрхийг дадлагажуулагч малчинтай эсэхийг харгалзаж үзээгүй байна.
12. Малчин өрхийг малжуулахаар 2016, 2017 онд 454,800.0 мянган төгрөгийн мал худалдаж авахдаа хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна.

13. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд байгуулсан гэрээний хугацаа дуусаагүй хэдий ч эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөх төлбөрөөс 1,502.0 мянган төгрөгийг хугацаанд нь төлүүлээгүй байна.
14. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2017 онд 100 хувь эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон санхүүгийн дэмжлэгээс гэрээний хугацаа дуусаагүй боловч гэрээнд заасан эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлбөл зохих 1,635.0 мянган төгрөгийг төлүүлээгүй байна.
15. Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон санхүүгийн дэмжлэгийн гэрээний хугацаа дуусаагүй боловч гэрээнд заасан эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөх төлбөрөөс 3,051.4 мянган төгрөгийг хугацаанд нь төлүүлээгүй байна.
16. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд 2017 онд 100 хувь эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон санхүүгийн дэмжлэгээс гэрээний хугацаа дуусаагүй боловч гэрээнд заасан эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлбөл зохих 33.8 мянган төгрөгийг төлүүлээгүй байна.
17. ХЭҮЗ-ийн 2015 оны 09 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн 3 дугаар зүйлийн 3.3.1 дахь заалт -д заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төслийг сонгон шалгаруулалтыг үзэхэд нэг ажлын байранд 1,000.0 мянган төгрөгөөр тооцож, 5,000.0 хүртэл мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгохоор заасан боловч дэмжлэг авсан 20 иргэдэд 500.0 мянган төгрөгийн дэмжлэг өгсөн.
18. "Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгч, төгсөгчийн бүлэгт эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэг олгох гэрээ"-г байгуулахдаа гэрээний батлагдсан загварын 3 дугаар зүйлийн 3.9 дэх заалт /Нийгмийн даатгалын сайн дурын эсвэл заавал даатгалд хамрагдсан байна/-ыг орхигдуулсан бөгөөд төсөлд хамрагдсан 13 иргэний 11 иргэн нийгмийн даатгалд огт хамрагдаагүй байна.
19. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2016 онд 44, 2017 онд 20, нийт 64 иргэн санхүүгийн дэмжлэг авсан боловч гэрээнд заасны дагуу нийгмийн даатгалд хамруулаагүй, ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2016 онд 96, 2017 онд 39, нийт 135 иргэн санхүүгийн дэмжлэгт хамрагдаж, үүнээс 20 иргэн нийгмийн даатгалд даатгуулсан байна. Энэ нь нэг талаараа бодит ажлын байр бий болгосон гэж үзэхэд хүндрэлтэй байна.
20. Бүлгийн зохион байгуулалтаар хүнсний ногоо тариалах хөтөлбөрийн хүрээнд "Тээвэрчин Алтай" ХХК-тай 3 улирлын хүлэмжийг 18,752.0 мянган төгрөгөөр гүйцэтгүүлж, 2018 оны 3 сарын 1-нд хүлээн авахаар гэрээ байгуулсан байна. Гэрээний хугацаанд гүйцэтгэгч компаниас хугацаа сунгах хүсэлт ирүүлсний дагуу ХХҮГ-аас 2018 оны 5 сарын 25-нд хүртэл сунгахаар албан тоотоор мэдэгдсэн боловч хариуцсан ажилтны хариуцлагагүй үйлдлээс тухайн үед хуулийн дагуу гэрээнд өөрчлөлт оруулаагүй байна. Аудитын явцад гэрээнд 2 удаа өөрчлөлт оруулж 7 сарын 1-нд хүлээн авахаар гэрээг сунгасан байна.
21. Төрийн аудитын байгууллагаас 2014 онд хийсэн нийцлийн аудитаар тогтоосон төлбөрийн актаас 16,235.3 мянган төгрөг, 2017 оны СТА-аар тогтоосон төлбөрийн актнаас 2,404.5 мянган төгрөгийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Илрүүлэлтэнд үндэслээд дараах дүгнэлтүүдийг гаргаж байна.

- ✚ Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийг төвлөрүүлснээр орлогын эх үүсвэр нэмэгдэж, үйл ажиллагааны үр дүн нэмэгдэх боломжтой байна.
- ✚ Хөтөлбөрүүдэд шаардлага хангасан иргэдийг хамруулсан бөгөөд ажлын байрыг нэмэгдүүлж, үр өгөөжийг бий болгосон байна.
- ✚ Дотоод хяналт хийж байгаа гэх боловч нотлох баримт, ажлын тайлан хангалтгүй, сонгон шалгаруулалтын баримт материал байхгүй, гэрээний бүрдэл хэсгүүд дутуу байгаагаас харахад үр дүнгүй ажил болжээ.

Ерөнхий Дүгнэлт

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд мал худалдан авахдаа худалдан авах ажиллагааны журам мөрдөөгүй, санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэд нийгмийн даатгалд бүрэн хамрагдаагүй байгаа зөрчлийг эс тооцвол ХЭДС-гийн хөтөлбөрүүд үр дүнтэй хэрэгжиж байна.

Дээрх дүгнэлтэнд үндэслээд дараах шийдвэр гаргалаа.

Төлбөрийн акт

ХХҮГ-ын дарга М.Мянганбууд

1. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, хувиараа хөдөлмөр эрхлэгч нөхөрлөл хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэдийн гэрээт хугацаанд төлөгдөөгүй 19,412.9 мянган төгрөгийг төлүүлж ХЭДС-д төвлөрүүлэх

Зөвлөмж

Аймгийн Засаг дарга С.Гансэлэмд

1. Орон нутгийн харьяаны төсөвт байгууллагуудын 2018 оны төсвийн тодотголд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийг тусгах ажлыг зохион байгуулах
2. ХЭСЗ-ийг хууль тогтоомж болон дүрмийн дагуу томилж, үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллахыг зөвлөж байна.

ХХҮГ-ын дарга М.Мянганбууд

1. Төслийн сонгон шалгаруулалт хийхдээ ирүүлсэн бүх төслийн хөтөлбөрт заасан шалгуур үзүүлэлтүүдийг хангаж буй эсэхийг тодорхойлж баримтжуулах
2. Төрийн аудитын байгууллагаас 2014 онд хийсэн нийцлийн аудитаар тогтоосон төлбөрийн актын хэрэгжээгүй үлдэгдэл 16,235.3 мянган төгрөг, 2017 оны СТА-аар тогтоосон төлбөрийн актын хэрэгжээгүй үлдэгдэл 2,404.5 мянган төгрөгийг хэрэгжүүлж ажиллах.

МХГ-ын дарга Б.Түмэнбаатарт

1. Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүн ажиллуулаагүйн төлбөртэй холбоотой зөрчлийг арилгах арга хэмжээг зохион байгуулах.

Албан шаардлага

ХХҮГ-ын дарга М.Мянганбууд

1. Нийгмийн даатгалын хэлтэстэй уялдаатай ажиллаж хөгжлийн бэрхшээлтэй судалгааг байнга шинэчлэн, ажил олгогчийн төлбөрийг цаг хугацаанд нь төлүүлэх
2. ХЭҮЗ-ийн тогтоолоор батлагдсан хөтөлбөрүүдэд заасан шалгуур үзүүлэлтийг мөрдөж, хөтөлбөрт хамрагдаж байгаа иргэдтэй байгуулсан гэрээний бүрдлийг хангаж, аудитаар илэрсэн зөрчлийг арилган цаашид давтан гаргахгүй байх

3. МХЭД хөтөлбөрийн хүрээнд мал худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулах
4. Гэрээний эргэн төлөлтийн хуваарьт заасан хугацаанд төлөгдөөгүй санхүүгийн дэмжлэгийг төлүүлэх
5. Батлагдсан загварын дагуу гэрээг байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж хэвших
6. "Тээвэрчин Алтай" ХХК-тай байгуулсан гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж үр дүнг тооцох
7. Ажилдаа хариуцлагагүй хандсан Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга Х.Энхтайванд хуулийн дагуу хариуцлага тооцох

ДАРГА , ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

Холбогдох байгууллагын санал

Тайлан шийдвэрийн төслийг ХХҮГ-т 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдөр 162 тоот албан бичгээр хүргүүлсэн. Холбогдох саналыг 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдөр багтаан авахаар албан тоотод дурьдсан боловч албан бичгээр хариу ирүүлээгүй тул саналгүй гэж үзлээ.